



**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ**



**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ,  
ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ ЖИЛИЙН  
АЖЛЫН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот  
2019 он**

## ГАРЧИГ

1.	НЭГ. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3-5
2.	ХОЁР. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР	6
3.	2.1 Эрүүгийн хэргийн танхим	7-11
4.	2.2 Иргэний хэргийн танхим	12-18
5.	2.3 Захиргааны хэргийн танхим	19-23
6.	ГУРАВ. БУСАД АСУУДЛААР	24-32
7.	ДӨРӨВ. ТАМГЫН ГАЗРЫН АЖЛЫН ТАЛААР	33
8.	4.1 Жилийн тэргүүлэх зорилтын үр дүн, хэрэгжилт	34-43
9.	4.2 Захиргаа удирдлагын хэлтсийн ажлын тайлан	43-52
10.	4.3 Шүүхийн зохион байгуулалтын хэлтсийн ажлын тайлан	53
11.	4.4 Шүүхийн практик судлалын хэлтсийн ажлын тайлан	54-55
12.	4.5 Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн ажлын тайлан	56-58
13.	4.6 Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн ажлын тайлан	59-61
14.	4.7 Ерөнхий шүүгчийн ажлын албаны ажлын тайлан	61-63
15.	4.8 Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны ажлын тайлан	63-67
16.	4.9 Сургалт семинар	67-69




# МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ


## НЭГ. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



Улсын Дээд шүүх 2019 онд нийт 3015 хэрэг хүлээн авч,  
танхимуудад хуваарьлагдсан байдал:




Шүүх хуралдаанаар 2114 хэрэг хянан шийдвэрлэж, тэдгээр нь  
танхимуудад ногдсон байдал:




Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимуудын  
2019 онд хүлээж авсан хэргийг өмнөх онтой харьцуулбал:



2019 онд шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргийг  
өмнөх онтой харьцуулбал:



Улсын Дээд шүүхийн нэг шүүгчид ногдох хэрэг,  
ажлын ачааллыг өмнөх онтой харьцуулбал:



## ХОЁР. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР




### 2.1. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ



## ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ

Эрүүгийн хэргийн танхим 2018 оны үлдэгдэл **10** хэрэг дээр 2019 онд хяналтын шатны журмаар эрүүгийн **952**, цагаатгалын **9**, нийт **971** хэрэг хүлээн авч, эрүүгийн **665**, цагаатгалын **9** буюу нийт **674** хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **130** хэргийг шүүгчийн захирамжаар буцааж, **129** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, **38** хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан эрүүгийн 971 хэргээс



**Эрүүгийн хэргийн танхимын** хяналтын шатны шүүх хуралдаан нийт **63** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **10.7** хэрэг хэлэлцжээ.

Эрүүгийн хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн **842** хэргээс нэг шүүгчид **210** хэрэг ногдож байна.


Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн **674** хэргийн **42.4** хувь буюу **286** хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, **32.2** хувь буюу **217** хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, **25.4** хувь буюу **171** хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгожээ.

Өөрчлөлт оруулсан **217** хэргийн **37.8** хувь буюу **82** хэргийг бусад, **36.4** хувь буюу **79** хэргийн зүйлчлэл өөрчлөлгүйгээр ялыг хөнгөрүүлсэн, **14.7** хувь буюу **32** хэргийг давж заалдах, хяналтын шатны шүүхээс ял хүндрүүлж шийдвэрлэснийг хүчингүй болгосон, **4.1** хувь буюу **9** хэргийг Эрүүгийн хууль буруу тайлбарлан хэрэглэсэн, **3.3** хувь буюу **7** хэргийг хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, **2.3** хувь буюу **5** хэргийг хэрэглэх ёстой хууль хэрэглээгүй, **1.4** хувь буюу **3** хэргийн зүйлчлэл өөрчлөлгүйгээр ялыг хүндрүүлсэн үндэслэлээр тус тус өөрчилсөн байна.

Хүчингүй болгосон **171** хэргийн **41** хувь буюу **70** хэргийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгож, **34** хувь буюу **58** хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцааж, **12.8** хувь буюу **22** хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцааж, **12.2** хувь буюу **21** хэргийг хэрэгсэхгүй болгож (үүнээс **4.6** хувь буюу **8** нь цагаатгалын хэрэг) шийдвэрлэжээ.

Хяналтын журмаар шүүгч Б.Батцэрэн **216**, Д.Ганзориг **210**, Ч.Хосбаяр **208**, Д.Эрдэнэбалсүрэн **208**, Ерөнхий шүүгчийн ажлын алба **129** эрүүгийн хэрэг тус тус хүлээн авчээ.

#### Шүүгч тус бүрийн болон Ерөнхий шүүгчийн ажлын албаны хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Б.Цогт **674**, шүүгч Д.Ганзориг **674**, Б.Батцэрэн **664**, Д.Эрдэнэбалсүрэн **662**, Ч.Хосбаяр **640**, С.Батдэлгэр **54**, О.Зандраа **2** удаа тус тус оролцсоноос; Танхимын тэргүүн Б.Цогт **674** хэргийн шүүх хуралдааныг даргалж;



Шүүгч Б.Батцэрэн **176**, Ч.Хосбаяр **171**, Д.Эрдэнэбалсүрэн **167**, Д.Ганзориг **160** хэргийг илтгэсэн байна.

### Эрүүгийн хэргийн танхимын шүүгчдийн 2019 оны ажлын ачаалал



Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн **8** хүнд холбогдох **8** цагаатгалын хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож, тэднийг цагаатгаж, **1** хүнд холбогдох **1** хэргийн цагаатгасан тогтоолд өөрчлөлт оруулж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **57** хувь буюу **384** хэргийг өмгөөлөгчийн гомдлоор, **14.7** хувь буюу **99** хэргийг ялтны гомдлоор, **11.4** хувь буюу **77** хэргийг улсын яллагчийн эсэргүүцлээр, **7.8** хувь буюу **53** хэргийг прокурор (цагаатгал 9)-ын дүгнэлтээр, **5.5** хувь буюу **37** хэргийг хохирогчийн гомдлоор, **2.8** хувь буюу **19** хэргийг хууль ёсны төлөөлөгчийн гомдлоор, **0.5** хувь буюу **3** хэргийг иргэний хариуцагчийн гомдлоор, **0.3** хувь буюу **2** хэргийг цагаатгагдсан этгээдийн гомдлоор хэлэлцжээ.

Улсын дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн **23** хэргийн **65.3** хувь буюу **15** хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол, шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгож, **13** хувь буюу **3** хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолд өөрчлөлт оруулж, **21.7** хувь буюу **5** хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол, шүүгчийн захирамжийг хүчингүй болгожээ.

Улсын дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **13** хувь буюу **3** хэргийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр, **13** хувь буюу **3** хэргийг хоёр шүүгчийн тусгай санал гаргасан үндэслэлээр, **8.7** хувь буюу **2** хэргийг Улсын ерөнхий прокурорын эсэргүүцлээр, **4.4** хувь буюу **1** хэргийг прокурорын дүгнэлтээр, **60.9** буюу **14** хэргийг ялтан, хохирогчийн өмгөөлөгчийн гомдлоор хэлэлцжээ.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **674** хэргийг гэмт хэргийн төрлөөр авч үзвэл:

- Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг **100**;
- Хулгайлах гэмт хэрэг **90**;
- Хүчиндэх гэмт хэрэг **73**;
- Хүнийг алах гэмт хэрэг **70**;
- Залилах гэмт хэрэг **62**;
- Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг **58**;
- Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг **44**,
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг **21**,
- Дээрэмдэх гэмт хэрэг **18**,
- Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг **16**,
- Хөрөнгө завших гэмт хэрэг **13**,
- Мал хулгайлах гэмт хэрэг **11**,
- Хахууль авах гэмт хэрэг **6**,
- Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах гэмт хэрэг **4**,
- Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг **4**,
- Хахууль өгөх гэмт хэрэг **3**,
- Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах **3**,
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг **2**,
- Хүн худалдаалах **1**,
- бусад төрлийн гэмт хэрэг **75** байна.

Тайлангийн хугацаанд шүүгч Д.Ганзориг **42**, Д.Эрдэнэбалсүрэн **35**, Б.Батцэрэн **31**, Ч.Хосбаяр **22**, нийт **130** хэргийг хянаж шүүгчийн захирамжаар буцаасан байна.

Эрүүгийн хэргийн танхим 2019 онд нийт **133** албан бичиг, **45** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Б.Цогт **85** албан бичиг, **13** өргөдөл гомдол, шүүгч С.Батдэлгэр **36** албан бичиг, **30** өргөдөл, гомдол, Ч.Хосбаяр **3** албан бичиг, Б.Батцэрэн **2** албан бичиг, **1** өргөдөл гомдол, Д.Эрдэнэбалсүрэн **2** албан бичиг, Д.Ганзориг **1** өргөдөл гомдол тус тус хянан шийдвэрлэж, одоо **5** албан бичгийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний захирамж **798** гарснаас шүүх бүрэлдэхүүн томилох тухай **699**, шүүхийн харьяалал тогтоох тухай **72**, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа сунгах тухай **27** захирамж гарчээ. Мөн тайлангийн хугацаанд шүүхийн тогтоол **51**, мэдэгдэх хуудас **203** гарсан байна.




## 2.2. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ

## ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ

Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **89** хэрэг дээр хяналтын шатны журмаар **1022**, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **221**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **38**, нийт **1370** хэрэг хүлээн авч, **1004** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар, **224** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, **36** хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулах эсэхийг хэлэлцэж, **54** хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзаж, **15** хэргийн харьяаллыг тогтоож, одоо шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулах хүсэлттэй **3**, хяналтын журмаар гаргасан гомдолтой **34**, нийт **37** хэргийн үлдэгдэлтэй байна.

### Нийт хүлээн авсан иргэний 1370 хэргээс



**Иргэний хэргийн танхимын** хяналтын шатны шүүх хуралдаан нийт **53** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **19,6** хэрэг хэлэлцжээ.

Иргэний хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн **1092** хэргээс нэг шүүгчид **156** хэрэг ногдож байна.

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн **1004** хэргийн **63** хувь буюу **634** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **14** хувь буюу **142** хэргийн шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулж, **10** хувь буюу **101** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж, **10** хувь буюу **101** хэргийн магадлалыг бүхэлд нь буюу

зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилж, **3** хувь буюу **26** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.


Өөрчлөлт оруулсан **142** хэргийн **62.7** хувь буюу **89** хэргийг хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **37.3** хувь буюу **53** хэргийг шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалыг өөрчилсөн байна.

Хүчингүй болгосон **101** хэргийн **50.5** хувь буюу **51** хэргийг шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж, **49.5** хувь буюу **50** хэргийг шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ. Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон **26** хэргийн **80.8** хувь буюу **21** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, **19.2** хувь буюу **5** нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлттэй **35** хэргийн **34** хэрэгт хүсэлтийг хангахгүй орхиж, **1** хэргийн хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн байна.

Хяналтын журмаар шүүгч Б.Ундрах **160**, Г.Алтанчимэг **157**, Х.Эрдэнэсүвд **157**, П.Золзаяа **155**, Д.Цолмон **155**, Г.Цагаанцоож **154**, Ц.Амарсайхан **154** хэрэг тус тус хүлээн авчээ.

#### Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **662**, шүүгч Г.Цагаанцоож **722**, Б.Ундрах **698**, Х.Эрдэнэсүвд **688**, Г.Алтанчимэг **680**, Д.Цолмон **623**, П.Золзаяа **573**, Ц.Амарсайхан **462** удаа **оролцсоноос**;

Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **661**, шүүгч Б.Ундрах **155**, Г.Цагаанцоож **124**, П.Золзаяа **60**, Ц.Амарсайхан **31**, Г.Алтанчимэг **9** хэргийн шүүх хуалдааныг **даргалж**;

Шүүгч Г.Алтанчимэг **154**, П.Золзаяа **150**, Г.Цагаанцоож **154**, Б.Ундрах **150**, Х.Эрдэнэсүвд **147**, Ц.Амарсайхан **144**, Д.Цолмон **141** хэргийг **илтгэсэн** байна.

### Иргэний хэргийн танхимын шүүгчдийн 2019 оны ажлын ачаалал



Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **67** хувь буюу **673** хариуцагчийн, **31.6** хувь буюу **317** нэхэмжлэгчийн, **1.3** хувь буюу **13** гуравдагч этгээдийн, **0.1** хувь буюу **1** прокурорын гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **1004** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

- Иргэний хуулиар **678**,
- Хөдөлмөрийн тухай хуулиар **219**,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар **52**,
- Гэр бүлийн тухай хуулиар **29**,
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар **5**,
- Бусад хуулиар **21** хэрэг байна.

Мөн энэ хугацаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **560 327 157** /Тав зуун жаран сая гурван зуун хорин долоон мянга нэг зуун тавин долоо/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **298 555 935** /хоёр зуун ерэн найман сая таван зуун тавин таван мянга есөн зуун гучин тав/ төгрөгийг буцаан олгожээ.

Тус танхим **2019** оны бүтэн жилд нийт **80** албан бичиг, **27** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **45** албан бичиг, **22** өргөдөл, гомдол, шүүгч Г.Алтанчимэг **12** албан бичиг, Б.Ундрах **7** албан бичиг, **1** өргөдөл, гомдол, Г.Цагаанцоож **2** албан бичиг, Д.Цолмон **1** албан бичиг, **1** өргөдөл, гомдол, Ц.Амарсайхан **1** албан бичиг, П.Золзаяа **1** албан бичиг, **2** өргөдөл, гомдол, Х.Эрдэнэсүвд **7** албан бичиг, **1** өргөдөл, гомдол тус тус хянан шийдвэрлэж, одоо **4** албан бичгийн үлдэгдэлтэй байна.

**Иргэний хэргийн танхим 2019 оны бүтэн жилийн байдлаар Улс төрийн намын бүртгэлийн талаар дараах ажлыг хийжээ. Үүнд:**

- Ард түмний олонхийн засаглал намыг 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Монголын төв намыг 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 02 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Их эв намыг 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Ардчилсан намын шинэчлэн баталсан дүрэм, мөрийн хөтөлбөрийг 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Монгол ардын намын дүрмийн өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Гэр хороолол хөгжлийн намыг 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 06 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Монголын шинэчлэлт намыг 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 07 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Миний монгол намыг 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Бүгд найрамдах намын дүрмийн болон даргын өөрчлөлтийг 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 09 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Монголын төв намыг 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 10 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;



- Тусгаар тогтнол, эв нэгдлийн намын даргын өөрчлөлтийг 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 11 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Капталист намыг 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 12 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Монголын төв намыг 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Миний монгол намыг 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Үйлдвэрчний эв нэгдэл намыг 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 15 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Зон Олны намын дүрмийн өөрчлөлтийг 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 16 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Монгол Шинэчлэлт намыг 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 17 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Шудрага Иргэдийн Нэгдсэн Эвсэл намыг 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 18 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Сошл Либерал намыг 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Зүй Ёс намыг 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 20 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Монголын төв намыг 2019 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Ард түмний намын нэрийн өөрчлөлтийг 2019 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 22 дугаар тогтоолоор бүртгэхээс татгалзаж;
- Ард түмний олонхийн засаглал намын даргын болон дүрмийн өөрчлөлтийг 2019 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 23 дугаар тогтоолоор бүртгэхээс татгалзаж;
- Үйлдвэрчиний Эв нэгдэл намыг 2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Их Эргэн Сэргэлтийн үндэсний намыг 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 25 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Ард түмний олонхийн засаглал намын даргын өөрчлөлтийг 2019 оны 10 дугаар сарын 24-ий өдрийн 26 дугаар тогтоолоор бүртгэхээс татгалзаж;
- Монголын үндэсний сэргэн мандал намыг 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 27 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;

➤ Шудрага Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын дүрмийн өөрчлөлтийг 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 28 дугаар тогтоолоор бүртгэхээс татгалзаж,

➤ Ард түмний олонхийн засаглал намын дүрмийн өөрчлөлтийг 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 29 дугаар тогтоолоор бүртгэхээс татгалзаж тус тус шийдвэрлэсэн байна.

2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар Улсын дээд шүүхэд зохих журмын дагуу бүртгэгдсэн **35** улс төрийн нам байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **1352** гаргаснаас Танхимын тэргүүний “Шүүх бүрэлдэхүүн томилох тухай” **1093**, “Улсын тэмдэгтийн хураамж буцааж олгох тухай” **206**, “Гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” **14**, “Гомдол гаргаагүйд тооцох тухай” **39** шүүгчийн захирамж тус тус гарчээ.




## 2.3. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

## ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

Захиргааны хэргийн танхим 2018 оны үлдэгдэл 22 хэрэг дээр 2019 онд хяналтын шатны журмаар захиргааны 493 хэрэг, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан 92, Шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар 24, Шүүхийн ёс зүйн хорооны гомдолтой 26, Мэргэжлийн хариуцлагын хорооны гомдолтой 6, Давж заалдах шатны журмаар 11, нийт 674 хэргийг хүлээн авч, 436 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар, 22 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцох эсэхийг хэлэлцэж, 25 хэргийн гомдлыг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид гомдол гаргасныг хянан хэлэлцэж, 54 хэргийг хуралдаанд оролцуулахгүйгээр шийдвэрлэж, 105 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, одоо 32 хэргийн үлдэгдэлтэй байна.

### Нийт хүлээн авсан захиргааны 674 хэргээс



Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 56 өдөр хуралдаж, өдөрт дунджаар 8.6 хэрэг хэлэлцжээ.

Захиргааны хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн 569 хэргээс нэг шүүгчид 87.6 хэрэг ногдож байна.

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн **436** хэргийн **66.1** хувь буюу **288** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **10.5** хувь буюу **46** хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **23.4** хувь буюу **102** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.


Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон **102** хэргийн **52** хувь буюу **53** хэргийн магадлалыг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөлт оруулж, **24.5** хувь буюу **25** хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах шатны шүүхэд буцааж, **23.5** хувь буюу **24** хэргийн нэхэмжлэлийг болон хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байна.

Шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан **46** хэргийн **34.8** хувь буюу **16** хэргийг шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **34.8** хувь буюу **16** хэргийн шийдвэр, магадлалыг бусад, **30.4** хувь буюу **14** хэргийг хууль буруу хэрэглэсэн үндэслэлээр тус тус өөрчлөлт оруулжээ.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлттэй **22** хэргийн **21** хэрэгт хүсэлтийг хангахгүй орхиж, **1** хэргийн хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн байна.

Хяналтын журмаар шүүгч Б.Мөнхтуяа **98**, Д.Мөнхтуяа **96**, П.Соёл-Эрдэнэ **96**, Г.Банзрагч **95**, Ч.Тунгалаг **95**, Л.Атарцэцэг **64**, Х.Батсүрэн **25** захиргааны хэрэг тус тус хүлээн авчээ.

#### Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг:



Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн М.Батсуурь **339**, П.Соёл-Эрдэнэ **352**, Г.Банзрагч **327**, Д.Мөнхтуяа **323**,

Ч.Тунгалаг **311**, Б.Мөнхтуяа **305**, Л.Атарцэцэг **235**, Х.Батсүрэн **98** удаа **оролцсоноос**;

Танхимын тэргүүн М.Батсуурь **339**, шүүгч Л.Атарцэцэг **38**, Ч.Тунгалаг **36**, Д.Мөнхтуяа **25**, Х.Батсүрэн **11**, Б.Мөнхтуяа **9** хэргийн шүүх хуралдааныг **даргалж**;


Шүүгч Ч.Тунгалаг **84**, П.Соёл-Эрдэнэ **81**, Г.Банзрагч **77**, Б.Мөнхтуяа **72**, Д.Мөнхтуяа **70**, Л.Атарцэцэг **53**, Х.Батсүрэн **21** хэргийг **илтгэсэн** байна.

**Гомдлыг хүлээн авахаас татгалзсан захирамж** хэлэлцэх шүүх хуралдаанд шүүгч Г.Банзрагч **16**, П.Соёл-Эрдэнэ **14**, Д.Мөнхтуяа **12**, Ч.Тунгалаг **12**, Б.Мөнхтуяа **11**, Л.Атарцэцэг **8**, Х.Батсүрэн **2** удаа **оролцсоноос**;

Шүүгч Ч.Тунгалаг **7**, Б.Мөнхтуяа **5**, Д.Мөнхтуяа **5**, Л.Атарцэцэг **4**, П.Соёл-Эрдэнэ **3**, Х.Батсүрэн **1** хэргийн шүүх хуралдааныг **даргалж**;

Шүүгч Д.Мөнхтуяа **5**, П.Соёл-Эрдэнэ **5**, Л.Атарцэцэг **4**, Г.Банзрагч **4**, Б.Мөнхтуяа **3**, Ч.Тунгалаг **3**, Х.Батсүрэн **1** хэрэг илтгэсэн байна.

**Захиргааны хэргийн танхимын шүүгчдийн  
2019 оны ажлын ачаалал:**



Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **35** хувь буюу **169** итгэмжлэгдсэн төлөөлөгчийн, **28.4** хувь буюу **137** нэхэмжлэгчийн, **13.9** хувь буюу **67** өмгөөлөгчийн, **12.4** хувь буюу **60** хариуцагчийн, **6.2** хувь буюу **30** гуравдагч этгээдийн, **4.1** хувь буюу **20** гомдол гаргагчийн гомдлоор хянан хэлэлцжээ.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **436** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

- Газрын маргаан **97**
- Төрийн албаны маргаан **84**
- Ашигт малтмалын маргаан **31**
- Татварын маргаан **30**
- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой маргаан **20**
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан **15**
- Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалтай **12**
- Гаалийн маргаан **7**
- Мэргэжлийн хариуцлагын хорооны тогтоолтой **3**
- Сонгуулийн маргаан **2**
- Бусад маргаан **135** байна.

Мөн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **24,570,000** /хорин дөрвөн сая таван зуун далан мянга/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **3,931,200** /гурван сая есөн зуун гучин нэгэн мянга хоёр зуу/ төгрөгийг буцаан олгожээ.

Захиргааны хэргийн танхим **2019** онд нийт **30** албан бичиг, **11** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн М.Батсуурь **19** албан бичиг, **4** өргөдөл гомдол, шүүгч Д.Мөнхтуяа **3** албан бичиг, **1** өргөдөл гомдол, Г.Банзрагч **2** албан бичиг, **2** өргөдөл гомдол, Л.Атарцэцэг **2** албан бичиг, **1** өргөдөл гомдол, Б.Мөнхтуяа **2** албан бичиг, Ч.Тунгалаг **1** албан бичиг, **1** өргөдөл гомдол, Х.Батсүрэн **1** албан бичиг, П.Соёл-Эрдэнэ **1** өргөдөл гомдолд хариу өгч, одоо **1** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол **785** гаргаснаас “хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай” **463** захирамж, “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” **154** тогтоол, захирамж, “улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” **57** захирамж, “гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай” **48** захирамж, “гомдол хүлээн авахаас татгалзсан захирамжийг хянасан” **25** тогтоол, “шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэх тухай” **22** тогтоол, “гомдол гаргаагүйд тооцох тухай” **10** захирамж, “хүсэлт хэрэгсэхгүй болгох тухай” **4** тогтоол, “тогтоолд засвар оруулах тухай” **1** тогтоол “нэхэмжлэгч, хариуцагч нар эвлэрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай” **1** захирамж байна.

## **ГУРАВ. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНААС БУСАД АЖЛЫН ТАЛААР**

Улсын Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөн 5 удаа, Нийт шүүгчдийн хуралдаан 2 удаа хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцжээ. Тухайлбал:

### **Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар:**

1. 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хуралдаж “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зүйл, заалт Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай” асуудлыг хэлэлцэж, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт хүргүүлж;
2. 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хуралдаж “Сонгуулийн Ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшүүлэх тухай” асуудлыг хэлэлцэж Монгол Улсын Их Хурлын даргад нэр дэвшигчийг санал болгож шийдвэрлэжээ.

### **Улсын Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр:**

1. 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдөр хуралдаж “Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай” асуудлыг хэлэлцэж, зөвлөгөөнийг хойшлуулж;
2. 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хуралдаж “ Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид нэр дэвшүүлэх тухай” асуудлыг хэлэлцэж, шүүгч Д.Ганзоригийг Монгол Улсын Ерөнхийлөгчид санал болгож;
3. 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдөр хуралдаж “Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид нэр дэвшүүлэх тухай” асуудлыг хэлэлцэж шүүгч Х.Батсүрэнг Монгол Улсын Ерөнхийлөгчид санал болгож;
4. 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хуралдаж “Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай” асуудлыг хэлэлцэж шүүгч Л.Атарцэцэгийг Монгол Улсын Ерөнхийлөгчид санал болгож;
5. 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хуралдаж “Улсын Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний дэгт өөрчлөлт оруулах /шинэчлэн батлах/ тухай” асуудлыг хэлэлцэж ажлын хэсэг томилон ажиллуулахаар тогтож, хойшлуулж, “Улсын Дээд шүүхийн шүүгч танхим сэлгэн ажиллах тухай” асуудлыг хэлэлцэн хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал гаргах, холбогдох байгууллагад хүсэлт хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Ерөнхий шүүгчид даалгаж шийдвэрлэжээ.



Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нар нь:

- ❖ Актив удирдлагын тухай;
- ❖ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- ❖ Захиргааны ерөнхий хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- ❖ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- ❖ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай;
- ❖ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- ❖ Нотариатын тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- ❖ Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай;
- ❖ Өмгөөллийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- ❖ Төлбөрийн чадваргүйдлийн тухай;
- ❖ Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын тухай;
- ❖ Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- ❖ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- ❖ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- ❖ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- ❖ Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай;
- ❖ Монгол Улсын Шүүхийн хөгжлийн дунд хугацааны бодлого;
- ❖ Бүх шатны шүүх, шүүхийн захиргааны байгууллагад төрийн болон албаны нууцыг хамгаалах журам;
- ❖ Шүүгчийг сонгон шалгаруулах журам;
- ❖ Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам;
- ❖ Иргэн, захиргааны хэргийн баримтын төрөлжсөн архивын ажлын заавар болон дээрх төслүүдэд тус тус санал өгч, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үүргээ хэрэгжүүлжээ.

Түүнчлэн:

1. Танхимын тэргүүн Б.Цогт, шүүгч С.Батдэлгэр нар “Шүүхийн тухай багц хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийн гишүүнээр;

2. Танхимын тэргүүн Б.Цогт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн гишүүнээр;

- Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын гишүүнээр;

3. Танхимын тэргүүн Х.Сонинбаяр, шүүгч Ц.Амарсайхан, П.Золзаяа нар “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр;

4. Танхимын тэргүүн Х.Сонинбаяр Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/ иргэний хэргийн мониторингийн ажлын хэсгийн ахлагчаар;

- Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс эрхлэн гаргадаг “Шүүх эрх мэдэл” мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхэтгэлийн редакцийн зөвлөлийн гишүүнээр;

5. Танхимын тэргүүн М.Батсуурь Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системийг зүгшрүүлэх ажлын хэсгийн ахлагчаар;

- “Өмгөөлөл” сэтгүүлийн редакцийн гишүүнээр;

- “Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүнээр;

- “Хуульч, эдийн засагчийн нэгдсэн клуб”-ын гишүүнээр;

- “Төрийн албаны тухай” хуулийг дагалдан батлагдах Улсын Их Хурлын тогтоолын ажлын хэсгийн гишүүнээр;

- “Шүүх эрх мэдэл” сэтгүүлийн гишүүнээр;

- Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2018 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Шүүхийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг”-ийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр,

- “Хэргийн хөдөлгөөний удирдлага, бодлого зохицуулалт”-ын чиглэлээр шүүхийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах дэд ажлын хэсгийн гишүүнээр;

6. Танхимын тэргүүн М.Батсуурь, шүүгч Г.Банзрагч нар “Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хууль зөрчсөн талаарх Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбоотой эдгээр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн ажлын хэсгийн гишүүнээр;

7. Танхимын тэргүүн М.Батсуурь, шүүгч Д.Мөнхтуяа нар 2019 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнээр;

8. Шүүгч Х.Батсүрэн 2019 оны 5 дугаар сарын 09-ний өдрийг хүртэл “Монголын шүүгчдийн холбоо”-ны тэргүүнээр;

- “Шүүхийн мэргэжлийн хариуцлагын хороо”-ны гишүүнээр;

9. Шүүгч Г.Банзрагч Монголын Хуульчдын холбооны “Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо”-ны гишүүнээр;

10. Шүүгч Б.Батцэрэн Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнээр;

11. Шүүгч Б.Батцэрэн, Д.Эрдэнэбалсүрэн нар “Эрүүгийн хууль”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” ажлын хэсгийн гишүүнээр;

12. Шүүгч Д.Мөнхтуяа Шүүгчдийн холбооны “Улсын Дээд шүүхийн салбар зөвлөл”-ийн гишүүнээр;

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр;

13. Шүүгч П.Соёл-Эрдэнэ Нотариатын сахилгын зөвлөлийн гишүүнээр;

14. Шүүгч Г.Алтанчимэг, С.Батдэлгэр, Ч.Тунгалаг нар “Монгол Улсын Шүүхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр;

15. Шүүгч Ч.Хосбаяр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүнээр;

16. Шүүгч Д.Цолмон, Б.Ундрах нар Иргэний буюу худалдааны асуудлаарх шүүхийн болон шүүхийн бус баримт бичгийг гадаадад хүргүүлэх тухай конвенц, Иргэний буюу худалдааны асуудлаарх хилийн чанад дахь нотлох баримтыг гаргуулан авах тухай конвенц, Шүүх үйл ажиллагаанд олон улс тэгш оролцох тухай конвенцид Монгол улс нэгдэж орох асуудлыг судалж, санал дүгнэлт болон холбогдох хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр;

17. Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн “Өмгөөллийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсгийн гишүүнээр;

- Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүнээр;

- Монголын Хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр тус тус ажилласан байна.

Түүнчлэн Эрүүгийн хэргийн Танхимын тэргүүн Б.Цогт, шүүгч Б.Батцэрэн, Д.Ганзориг, Ч.Хосбаяр, Д.Эрдэнэбалсүрэн нар Эрүүгийн эрх зүйн сургагч багшаар ажиллажээ.

**Сэтгүүлийн нийтлэл, тойм, гарын авлагын хувьд:**

1. Танхимын тэргүүн М.Батсуурь нь Д.Цолмонгийн “Хуулийн сургуульд сурсан 101 зүйл”, шүүгч Г.Банзрагчийн “Захиргааны процессын эрх зүй” номыг тус тус хянан редакторлаж;

2. Шүүгч Г.Банзрагч 2019 оны 11 дүгээр сард “Захиргааны процессын эрх зүй” сурах бичгийг эрхлэн бүтээж, хэвлүүлж;

3. Шүүгч Б.Батцэрэн “Өмгөөлөгч” эрх зүйн онол, практикийн арга зүй сэтгүүл, 2019 он, дугаар №29/88/-д “Шүүх хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал” сэдэвт өгүүлэл нийтлүүлж;

- “Монголын төр эрх зүй” онол арга зүйн сэтгүүл, 2019 он, дугаар №4/93/-д “Шинэчлэн найруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дахь гэрчээс мэдүүлэг авах ажиллагаанд анхаарах асуудлууд” сэдэвт өгүүлэл нийтлүүлж;

4. Танхимын тэргүүн Х.Сонинбаяр, шүүгч П.Золзаяа нар Иргэний хэргийн шүүгч нарт зориулсан сургалтын гарын авлагыг боловсруулж;

5. Иргэний хэргийн танхимын шүүгч нар “2018 онд улсын хэмжээнд хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тойм” сэдэвт тойм боловсруулж, шүүн таслах ажлын зэрэгцээ сургалт, судалгааны болон нэг сэдэвт бүтээл, өгүүлэл, тойм бэлтгэхэд оролцжээ.

**Сургалт, семинарын уулзалт-ярилцлагын хувьд:**

Улсын Дээд шүүхийн Танхимын тэргүүн, шүүгч нар нь дараах уулзалт-ярилцлагыг зохион байгуулах, оролцох хэлбэрээр ажиллажээ. Тухайлбал,

- Танхимын тэргүүн Б.Цогт 2019 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Нийслэл дэх анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчидтэй “Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик” сэдэвт уулзалт-ярилцлага;

- Танхимын тэргүүн Б.Цогт, шүүгч Д.Ганзориг нар 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Нийслэл дэх эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хариуцсан шүүгч нартай уулзалт-ярилцлага;

- Танхимын тэргүүн М.Батсуурь 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдөр НҮБ-ын тусгай илтгэгч М.Форстой “Хүний эрх”-ийн асуудлаар;

- 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны Ардчилсан институт, Хүний эрхийн албаны төлөөлөгчтэй Сонгуулийн хууль эрх зүйн орчинтой холбоотой асуудлаар;

- Шүүгч Г.Банзрагч 2019 оны 11 дүгээр сарын 31-ний өдөр “Оюуны-Инноваци” ТББ-д “Захиргааны шүүхэд гаргах нэхэмжлэлийн шаардлагын төрөл, түүний үр дагавар”-ууд сэдвээр “Подкаст” ярилцлага тус тус хийжээ.

Мөн тайлангийн хугацаанд Улсын Дээд шүүхийн Танхимын тэргүүн, шүүгч нар дараах сургалтуудад хамрагджээ.

- Шүүгч Б.Батцэрэн, Д.Ганзориг, Ч.Хосбаяр, Д.Эрдэнэбалсүрэн нар Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан эрүүгийн эрх зүйн сургагч багш нарт зориулсан “Виртуал мөнгө” сэдэвт;

- Шүүгч Л.Атарцэцэг, Б.Мөнхтуяа, Д.Мөнхтуяа, Г.Банзрагч, П.Соёл-Эрдэнэ нар Шүүхийн Ерөнхий зөвлөл, Ханнс-зайдел сангийн Эрх зүйн боловсрол академитай хамтран 2019 оны 06 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Захиргааны эрх зүйн сургалтын сургагч багшийг чадавхжуулах” сэдэвт;

- Танхимын тэргүүн Б.Цогт, шүүгч Б.Батцэрэн, Д.Ганзориг, Ч.Хосбаяр, Д.Эрдэнэбалсүрэн нар Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс 2019 оны 09 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулсан “Эрүүгийн эрх зүйн сургагч багшийг чадавхжуулах сургалт” сэдэвт, Хууль зүй, дотоод хэргийн яам, Нээлттэй нийгэм форумаас хамтран 2019 оны 12 дугаар сарын 11-13 өдрүүдэд зохион байгуулсан “Эрүүгийн хууль тогтоомж: Сургагч багшийн сургалт” сэдэвт сургалтад тус тус хамрагдсан байна.

Түүнчлэн Улсын Дээд шүүхийн шүүгч нар 2019 онд доорх сэдвүүдээр хичээл зааж, илтгэл хэлэлцүүлжээ. Тодруулбал,

- Шүүгч Г.Банзрагч 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Японы Нагоягийн их сургууль, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Монголын хуульчдын холбоо, Ханнс-зайделийн сангийн хамтран зохион байгуулсан “Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн үндсэн асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд “Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрөл, шаардлага тэдгээрт тавигдах нийтлэг болон тусгай урьдчилсан нөхцлүүд” сэдвээр;

- Шүүгч Б.Батцэрэн 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Улсын ерөнхий прокурорын газраас зохион байгуулсан “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлэгт “Шүүх хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал” сэдвээр;

- Шүүгч Д.Мөнхтуяа 2019 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Монгол Хуульчдын холбооноос зохион байгуулсан “Эрх зүйн шинэчлэлд хуульчдын үүрэг, оролцоо” сэдэвт “Хуульчдын форум-2019” хуралдаанд “Шүүгчийн томилгоо” сэдвээр;

- Шүүгч Б.Батцэрэн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан “Засгийн газраас өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх хэлэлцүүлэгт” “Шүүхээс эрүүгийн хууль тогтоомжийг хэрэглэх, түүнд тулгамдаж буй асуудал” сэдвээр;

- Шүүгч Ч.Хосбаяр 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Шударга ёс ба олон нийтийн итгэл” сэдэвт хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнд “Авлигын эсрэг конвенц ба шүүх эрх мэдэл” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлж,

- Эрүүгийн хэргийн танхим Ханнс-Зайделийн сантай хамтран 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Нийслэл дэх эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нарт зориулж “Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэхэд анхаарах асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулахад оролцжээ.

Түүнчлэн Танхимын тэргүүн, шүүгч нар нь:

- Танхимын тэргүүн М.Батсуурь 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Залуу хуульчдын клубын гишүүдэд захиргааны эрх зүйн чиглэлээр;

- Шүүгч Б.Батцэрэн 2019 оны 04 дүгээр сарын 10-11-ний өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан эрүүгийн хэргийн шүүхийн шүүгчид зориулсан “Хууль тайлбарлан хэрэглэх, онол арга зүй: Эрүүгийн эрх зүй” сэдэвт сургалтад “Эрүүгийн эрх зүйд хууль тайлбарлан хэрэглэх онцлог” сэдвээр;

- Шүүгч П.Золзаяа 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан шинээр томилогдсон шүүгч нарын сургалтад “Эвлэрүүлэн зуучлал” сэдвээр;

- Шүүгч Г.Банзрагч 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан Хууль зүйн их, дээд сургуулийн хуулийн багш нарт

зориулсан сургалтад “Захиргааны процессын эрх зүйн шинэчлэлтэй холбоотой асуудлууд” сэдвээр;

- 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “Шүүхийн мэргэшсэн сэтгүүлч-7” сургалтад сэтгүүлч нарт “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог” сэдвээр;

- Шүүгч П.Соёл-Эрдэнэ 2019 оны 5 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулсан хуульчийн үргэлжилсэн багц цагийн сургалтад “Захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ”, “Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн шаардлагын төрлүүд” сэдвээр мөн 2019 оны 10 дугаар сарын 24, 12 дугаар сарын 11-ний өдрүүдэд “Захиргааны байгууллагын үйл ажиллагааны зарчим”, “Сонгуулийн маргаан ба шүүхийн практик” сэдвээр;

- Шүүгч Г.Банзрагч, П.Соёл-Эрдэнэ нар 2019 оны 12 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд Улсын Дээд шүүх, Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс хамтран зохион байгуулсан захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд зориулсан сургалтад “Хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй: Захиргааны эрх зүй”, “Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон тэдгээрийн процессын хуулийг хэрэглэхэд анхаарах зарим асуудал”, “Захиргааны гэрээтэй холбоотойгоор гаргах нэхэмжлэлийн төрөл, тэдгээрийн онцлог, шүүхээр шийдвэрлэж буй байдал, анхаарах асуудлууд”, “Зөрчлийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэж буй шүүхийн практик болон бусад асуудлууд” сэдвээр;

- Танхимын тэргүүн Б.Цогт Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс 2019 оны 12 дугаар сарын 05, 10-ны өдрүүдэд зохион байгуулсан Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд зориулсан “Хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй: Эрүүгийн эрх зүй”, “Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай материаллаг болон процессын хуулийн практик хэрэглээний зарим асуудал” сургалтад “Мөнгө угаах гэмт хэргийн онцлог, түүнийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал” сэдвээр;

- Шүүгч Б.Батцэрэн “Шүүхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр бичих аргачлал, анхаарах зарим асуудал” сэдвээр;
- Шүүгч Д.Ганзориг “Нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдал, гэмт хэрэгт хамтран оролцох” сэдвээр;
- Шүүгч Ч.Хосбаяр “Албан тушаалын гэмт хэргүүдийн шинж, шалган тогтоох онцлог, анхаарах зарим асуудал” сэдвээр;
- Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн “Эрүүгийн хуулийн 1, 2 дугаар бүлэг дэх үндсэн зарчмууд, хууль буцаан хэрэглэх нь” сэдвээр тус тус хичээл заасан байна.

- Танхимын тэргүүн М.Батсуурь, шүүгч Д.Мөнхтуяа нар 2019 оны 2, 3 дугаар сард “Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2018 оны 183 дугаар, 2019 оны 15 дугаар тушаалаар зарлагдсан анхан шатны шүүхийн шүүгчийн, мөн зарим шүүхийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн сул орон тоонд нэр дэвшигчдээс авах шалгалт”-ыг зохион байгуулахад Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүний хувиар оролцож, шүүгчийн сонгон шалгаруулалтын шалгалт авах, үнэлгээ өгөх хэлбэрээр оролцож ажиллажээ.





## ДӨРӨВ. ТАМГЫН ГАЗРЫН АЖЛЫН ТАЛААР

## ҮНДСЭН ХЭСЭГ

Улсын Дээд шүүхийн Тамгын газар нь 2019 онд дараах тэргүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллалаа:

1. Хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахад ахиц гаргах, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын эрх зүйн тогтвортой орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шүүгч, шүүхийн захиргааны ажилтны нийгмийн баталгаа болон ажиллах нөхцөлийг сайжруулах, шүүхийн эдийн засгийн баталгааг бүрдүүлэх;

2. Менежментийн хөгжлийг тодорхойлсон Улсын Дээд шүүхийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахад судалгаа мэдээллийн туслалцаа үзүүлэх, хэрэгжилтийг хангуулах бэлтгэлийг урьдчилан зохион байгуулах;

3. Дэлхийн дээд шүүхүүдийн загвар, шүүн таслах ажиллагааны болон бусад ажиллагааны нийтлэг зохицуулалтыг судлах, энэ талаарх хөгжингүй орнуудын шилдэг туршлага судлах;

4. Цахим шүүх болох зорилтын хүрээнд дотоод цахим оффисын програм хангамжийг нэвтрүүлэх, энэ талаарх хөрш орны туршлага судлах;

5. Хууль тогтоомжийг мөрдүүлэх, байгууллагад хөндлөнгийн үнэлгээ хийлгэх зэрэг ажлуудыг чухалчилж, гүйцэтгэхэд анхаарлаа.



### **4.1. ЖИЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ҮР ДҮН, ХЭРЭГЖИЛТ**

#### **4.1.1. Дэлхийн дээд шүүх ном:**

Монгол Улсад орчин цагийн шүүх байгуулагдсаны 105 жилийн ой, Улсын Дээд шүүх байгуулагдсаны 90 жилийн ойд зориулсан "Монголын шүүх" цуврал номны IV дэх боть болох "Дэлхийн дээд шүүхүүд" нэг сэдэвт бүтээлийг хэвлэлтэд өгөхөд бэлэн болоод байна. Уг номонд дэлхийн таван тивийн нийт 30 гаруй улсын Дээд шүүхийн танилцуулга, тогтолцоо, бүтэц зохион байгуулалт, бүрэн эрх, шүүгчийг томилох журам, тавигдах шаардлага, тэдгээрт хүлээлгэх хариуцлага зэрэг сэдвүүдийг багтаасан бөгөөд график, тайлбар, зураг бүхий танин мэдэхүйн, харьцуулсан судалгааны бүтээл боловсруулагдаж дууслаа.

Түүнчлэн энэхүү бүтээл нь харилцан адилгүй эрх зүйн тогтолцоотой, дээд шүүхүүдийн бие даасан байдлын баталгааг хангах жишиг авахуйц, хөгжингүй болон

хөгжиж буй улс орнуудын Дээд шүүхийн туршлагыг агуулж буйгаараа онцлог бөгөөд 2020 оны 1 дүгээр улиралд нийтийн хүртээл болно.

#### **4.1.2. Гадаад харилцааны хүрээг өргөтгөж, сургалтыг тогтмолжуулах чиглэлээр:**

Улсын Дээд шүүх, БНСУ-ын Дээд шүүхийн хамтын ажиллагааны хүрээнд зогсонги байдалд байсан тус улсын Сөүл хотноо зохион байгуулагддаг “Монгол Улсын шүүхийн шүүгч, ажилтан нарт зориулсан” сургалтыг энэ жил 2019 оны 6 дугаар сарын 24-нөөс 7 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэ удаагийн сургалтаар БНСУ-ын Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаатай танилцаж, захиргааны хэргийн онцлог, захиргааны хэрэг маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх процесс ажиллагааны талаар хөндсөн ба шүүгч, ажилтнуудын сургалтыг тогтмолжуулах, оролцогчдын хүрээг өргөтгөх, сэдэв арга хэмжээг эрх зүйн шинэчлэлтэй уялдуулах талаар харилцан тохиролцов.



Эрүүгийн хэргийн тахимын тэргүүн Б.Цогт, шүүгч Ч.Хосбаяр, Х.Эрдэнэсүвд нар АНУ-ын Вашингтон хотноо 2019 оны 11 дүгээр сарын 03-08-ны өдрүүдэд Дэлхийн банкнаас зохион байгуулсан “Хууль, шударга ёс ба хөгжил” сэдэвт ээлжит чуулга уулзалтад оролцлоо.


Чуулга уулзалтаар технологийн дэвшлийг шүүхийн практикт хэрхэн нэвтрүүлэх, орчин үеийн технологийн чиг хандлага,



тухайлбал дата өгөгдөл, хиймэл оюун ухаан, өөрөө өөрийгөө хөгжүүлэгч машин, блок чайн зэрэг технологиудын хууль эрх зүйн үр дагаврыг судлан харилцан ярилцаж, уг технологийг нэвтрүүлэхэд үүсч болзошгүй ёс зүйн болоод хууль эрх зүйн асуудлыг хэлэлцжээ.

Түүнчлэн айлчлалын хүрээнд төлөөлөгч нар АНУ-ын Төрийн Департаментийн төлөөлөлтэй хоёр талын албан ёсны уулзалт хийж, Монгол Улсын шүүхийн шүүгч нарт зориулж “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь ял наймаалцах” сэдэвт сургалтыг хамтран зохион байгуулах талаар Ерөнхий шүүгчийн албан бичгээр хүргүүлсэн хүсэлтийг уламжилж, харилцан тохиролцоонд хүрэв. Ингэснээр Монголын шүүхийн шүүгчдийг чадавхжуулах, тэр дундаа эрүүгийн хэрэг дагнан шийдвэрлэдэг шүүгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, туршлага судлах, гадаад сургалтын шинэ замыг нээхэд дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Шүүгч Д.Мөнхтуяа, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга, Мэдээллийн технологи хариуцсан референт Э.Баярбаатар нар БНХАУ-ын Ардын Дээд шүүхээс Жеүжен мужийн Вүзен хотноо 2019 оны 12 дугаар сарын 02-07-ны өдрүүдэд зохион байгуулсан “Интернэт шүүх ба шударга ёс” сэдэвт чуулга уулзалтад оролцлоо.



Чуулга уулзалтад оролцогчид хиймэл оюун ухаан, онлайн платформд үндэслэн шүүх цахим хэлбэрээр шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх, улмаар шүүхийн үйл ажиллагааг бүхэлд нь цахим хэлбэрт шилжүүлсэн талаарх туршлагыг судалж, Монгол Улсад нэвтрүүлэх боломжийг эрэлхийллээ. Энэ нь Улсын Дээд

шүүх цахим шүүх болох зорилтын хүрээнд хийгдэж буй алхам бөгөөд цахим шүүх зорилтын хүрээнд хийгдэж буй гол ажлуудын нэг юм.

#### **4.1.3. Сургалт:**

Практик судлалын хэлтэс 2016 оноос Статистик судалгааны SPSS програмд үндэслэн Улсын Дээд шүүхийн хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн тогтоолоор өгөгдлийн сан үүсгэн тогтмол баяжуулан ажиллаж байна.

Тус хэлтсийн референт, шинжээчид 2019 оны 11 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд Статистик судалгааны мэдээллийг боловруулах SPSS програмд өгөгдөл хэрхэн оруулж, баяжуулах сургалтад хамрагдав. Сургалтын агуулгад судалгааны өгөгдөл цуглуулах аргачлал, асуулгын хуудас боловсруулах, мэдээллийг програмд оруулах, SPSS програм дээр өгөгдлийг зохиох, боловсруулах, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, дүгнэлтийн статистик суурь, нэг ба хоёр хувьсагчтай хүснэгт ба график байгуулах зэрэг сэдвүүд багтжээ.

Дээрх сургалтад хамрагдсанаар хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн тогтоолын өгөгдлийн санг боловсронгуй болгох, статистик дүн шинжилгээг хялбар хийх, түүнд үндэслэн судалгаа гаргахад чухал ач холбогдолтой сургалт боллоо.



2017 онд батлагдсан Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2019 оны 3, 36 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Улсын Дээд шүүхийн 2019-2023 оны стратеги төлөвлөгөө, төрийн захиргааны ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулаад байна.

Энэ нь төрийн албан хаагчдын албан тушаалын зорилго, зорилт, чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчид тавигдах шаардлагыг чадахуйн /мерит/ зарчимд нийцүүлэн тодорхойлох чухал ач холбогдолтой юм.

#### **4.1.4. Шүүхийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

Улсын Дээд шүүхийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны жилийн эцсийн болон 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гарган тайлагнаж, аудит хийлгэх, нэгтгүүлэхээр Үндэсний Аудитын газар, Сангийн яамны Төрийн сангийн газруудад тус тус хүргүүлээ.

Шүүхийн санхүүгийн үйл ажиллагаанд 2019 онд хийгдсэн 2019 онд тэргүүлэх чиглэлд тусгаж, хэрэгжүүлсэн ажлуудыг тоймлон авч үзвэл:

#### **Шүүхийн худалдан авах ажиллагааны хүрээнд:**

Шүүн таслах ажиллагааны хэвийн найдвартай, тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах, хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, их засварын ажлын өмнө нь хийгдсэн судалгаанд үндэслэн 2019 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаа.Төлөвлөгөөнд тусгагдсан **14** худалдан авалтын ажлуудыг нарийвчлан үзэхэд **8** тендерийг нээлттэйгээр, **4** тендерийг харьцуулалтын аргаар, **2** тендерийг шууд худалдан авах аргаар зохион байгуулах байснаас давхардсан тоогоор **12** удаа нээлттэйгээр, **4** удаа харьцуулалтын аргаар, **2** удаа шууд худалдан авах аргаар нийтдээ **3.9** тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг “ТБОНӨХБАУХА” тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэсэн байна. Тухайлбал;

- Дээврийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт **5** компани оролцож, “Фужи-Алтай” ХХК шалгарч **219,9** сая төгрөгөөр;

- Гадна фасад засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт **2** компани оролцож, “ГЦЦЭ” ХХК шалгарч **555,9** сая төгрөгөөр;

- Улсын Дээд шүүхийн конторын барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт **3** компани оролцож, “Баяндэ” ХХК шалгарч **491,2** сая төгрөгөөр;

- “Шүүгч нарын өрөө болон нийт шүүгчдийн хуралдааны танхимын засварын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт **3** компани оролцож, “Содон номин констракшн” ХХК-шалгарч **739,1** сая төгрөгөөр;

- Автомашин нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 4 багц бүхий тендерт 5 компани оролцож, 1-3-р багцад “Моннис моторс” ХХК шалгарч **955,1** сая төгрөгөөр, 4-р багцад "Номин моторс" ХХК шалгарч **91,4** сая төгрөгөөр;

-“Шүүн таслах ажиллагааны аюулгүй байдлын рентген, гар хайгч, дагалдах тоног төхөөрөмж” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт 3 компани оролцож, “Нанопланет” ХХК шалгарч **88,0** сая төгрөгөөр;

-“Шүүхийн тогтоол, захирамж, бусад эрх зүйн акт хэвлэх,хувилах, сүлжээний тоног төхөөрөмж худалдан авах” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 4 багц бүхий тендерт 5 компани оролцож,1-р багцад “Ай ти зон” ХХК шалгарч **309,7** сая төгрөгөөр, 2-р багцад "Глобалсмарт сольюшн” ХХК шалгарч **56,5** сая төгрөгөөр, 3-р багцад "Глобалсмарт сольюшн” ХХК шалгарч **69,0** сая төгрөгөөр, 4-р багцад "Вокомтехнологи” ХХК шалгарч **19,9** сая төгрөгөөр;


-“Тавилга худалдан авах” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 2 багц бүхий тендерт 7 компани оролцож,1-р багцад “Анун” ХХК шалгарч **300,9** сая төгрөгөөр, 2-р багцад "Оффис хөшиг” ХХК шалгарч **20,7** сая төгрөгөөр;

-Автотээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгалын тендерийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт 7 компани оролцож, “Ард даатгал” ХХК-тай **6,7** сая төгрөгөөр;

-“Шүүгчдийн амь нас эрүүл мэндийн даатгал”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт 3 компани оролцож, “Ард даатгал” ХХК-тай **40,1** сая төгрөгөөр;

-“Антивирусын програм” худалдан авах тендерт 3 компани оролцож, “Софтлайн азия” ХХК-тай **3,9** сая төгрөгөөр;

-“Программ хангамж худалдан авах” тендерт 3 компани оролцож, “ЕСМ” ХХК-тай **34,4** сая төгрөгийн ажлуудыг гүйцэтгэлээ.



Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 7.1.3-т “шүүгч, ажилтныг шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах” гэж заасны дагуу батлагдсан төсвийн хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хөрөнгө худалдан авах тухай зохих зөвшөөрөлийг авч, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах дээрх ажлуудыг хэрэгжүүлэхээр эрэмбэлсний дагуу хэрэгжүүлсэн байна.

Дээвэр засварын ажил:



Өмнө нь



Дараа нь

Гадна пасадны засварын ажил:



Өмнө нь:



Дараа нь

Түүнчлэн 2018 онд Монгол Улсын Засгийн газрын 69 дүгээр тогтоолоор Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх, Давж заалдах шатны шүүхүүдийн байрыг балансаас балансад шилжүүлсэнтэй холбогдуулан Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны заал танхим болон шүүгч, ажиллагсадын өрөө тасалгаанд их засварын ажлууд бүрэн хийгдэж, ажиллах орчны ая тухтай байдлыг хангахад 1189,5 сая төгрөгийн засвар, үйлчилгээний ажлууд хийж, гүйцэтгүүлсэн байна.



Өрөө тасалгааны тухайд өмнө нь байсан болон шинээр засварласан нь:



Өмнө нь:



Дараа нь

Хурлын танхимын засварын ажил:

Өмнө нь:



Тусдаа байсан 2 танхимыг нийлүүлэн шинээр засварласан байдал :



Улсын Дээд шүүх нь нийт 13 автомашинтайгаас 2019 онд хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 8 автомашин болох Ниссан теана -4ш, Ниссан урван-1ш, Ниссан патрул-1ш, Ниссан QX-1ш, Исузу маркын ачааны автомашин-1ш-ийг тус бүрийг нийтдээ 1046,5 сая төгрөгөөр худалдан авч автомашины парк шинэчлэлийг тодорхой түвшинд дээшлүүлж ажиллалаа. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хуучин автомашинуудаас Налайх дүүргийн болон Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхүүлд балансас балансад шилжүүлэхээр Төрийн өмчийн хороонд хүсэлтийг хүргүүлээд байна.



Архивын өрөө, номын сан, уншлагын танхимд засварын ажил хийж, архивын өрөөнд зориулалтын бетонон шал цутгаж, 10 ширхэг нягтруулсан шүүгээг шинээр суурилууллаа.

Архивын өрөө



Өмнө нь



дараа нь


#### **4.1.5. “Цахим оффис”-ын нэгдсэн систем**

2020 онд Улсын Дээд шүүхийн бичиг хэргийн эргэлтийг сайжруулах, ажлын хариуцлага, бүтээмж, эмх цэгцийг дээшлүүлэх, цахим бичиг хэрэг, архивын систем нэвтрүүлэх зорилгоор “Цахим оффис”-ын нэгдсэн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр бэлтгэл ажил хангагдаад байна.

Энэ системийг нэвтрүүлснээр удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, түүний биелэлт, хэрэгжилтийг хянах, ажлын бүтээмж дээшлэх, захиргааны ажлыг цаасан сууриас цахим суурьт шилжүүлэх боломжийг бүрдүүлж, олон тусдаа програмыг нэгтгэж уялдаа холбоотой нэг програмтай болох, цаг хугацаа хэмнэх, цаас болон хорны хэрэглээг бууруулах ач холбогдолтой юм.

Цахим оффисын програм нь бичиг хэргийн, өргөдөл гомдлын, архивын, хүний нөөцийн, намын, цагаатгалын гэсэн өгөгдлүүдээс бүрдэх бөгөөд үүрэг даалгавар, төлөвлөгөө, тайлан, файлын сан, тайлан мэдээ зэрэг үндсэн модултай байна.

Мөн иргэн, аж ахуйн нэгж нь Улсын Дээд шүүхийн цахим хуудсаар дамжуулан өргөдөл, гомдол гаргах боломжтой болох юм.



#### **4.1.6. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны улсын үзлэг явагдав:**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн “Улсын үзлэг явуулах тухай” 150 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн “Улсын үзлэгийг зохион байгуулах төв комиссын бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай” 46 дугаар захирамж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Улсын үзлэг явуулах хуваарь”-ийн дагуу Улсын Дээд шүүхийн Тамгын газарт 2019 оны 9 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны үзлэг явагдаж нийлбэр дүнгээр 91.8 хувь буюу “А” үнэлгээгээр дүгнэгдэв.

#### **4.2 ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС:**

##### **4.2.1 Шүүгчийн хараат бус байдлыг хангаж, хамгаалах чиглэлээр:**

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар шүүгч албан үүргээ гүйцэтгэх явцад амь нас, эрүүл мэндэд нь хохирол учирсан тохиолдолд даатгалын бусад төрлөөс үл хамааран олгогдох заавал даатгагдах албан журмын даатгалын төрлийг хуульчлан тусгасан. Хуулийн дээрх заалтын хэрэгжилтийг хангаж “Ард даатгал” ХК-тай “Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал”-ын гэрээг байгуулан эрсдэлээс хамгаалан ажиллаж байна. Ингэснээр даатгуулагчийн гэр бүлд баталгаатай орлогыг бий болгох, гэнэтийн эрсдэлээс үүсэх санхүүгийн ачааллыг бууруулах чухал ач холбогдолтой юм.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор иргэд болон хэргийн оролцогч нарыг зөвхөн “Б” байрны хаалгаар нэвтрүүлж, төрийн тусгай хамгаалалтын газрын шалган нэвтрүүлэгч хөдөлгөөнд нь хяналт тавин ажиллаж байна. Мөн ачаа тээш шалгах рентген аппарат, металл илрүүлэгч хаалга, метал хайгч гар багажуудыг шинээр худалдан авч, мэргэжлийн хяналтын байгууллагын зохих зөвшөөрлийн дагуу хөтөлбөр, дүрэм, төлөвлөгөөг батлуулж, Улсын Дээд шүүхийн төв хаалганд байршуулан ажиллуулж байна.

Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх нь Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны, эргүүл хамгаалалтын газрын Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтэстэй хамтран хяналтын шатны Эрүүгийн хэргийн **645**, Иргэний хэргийн **1171**, Захиргааны хэргийн **563** шүүх хуралдааны аюулгүй байдлыг ханган ажиллалаа.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар таслан сэргийлэх арга хэмжээ өөрчлөгдсөн шүүгдэгч нарт холбогдох 16 мэдэгдэх хуудсыг шуурхай удирдлагын төвд хүргүүлэн, орон нутгийн цагдаагийн газарт мэдэгдсэн бөгөөд шүүх хуралдаанд биечлэн оролцсон /таслан сэргийлэх арга хэмжээ өөрчлөгдсөн/ 4 шүүгдэгчийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн байна.

2019 оны 6 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд Улсын Дээд шүүхийн байрны гадаа “Баялаг бүтээгчдийг дэмжих” ТББ, “Манан дэглэмийн эсрэг тэмцэгч монгол түмний нэгдэл” ТББ-ын нэгдсэн жагсаал, цуглааны үед Цагдаагийн байгууллага болон Төрийн тусгай хамгаалалтын газраас нэмэгдэл хамгаалалт авч, хамтран ажилласан байна.

#### **4.2.2 Хүний нөөцийн талаар:**

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2019 оны 5 дугаар сарын 09-ний өдөр 74 дүгээр зарлиг гаргаж, Улсын Дээд шүүхийн санал болгосноор Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээр Хөхийсүрэнгийн Батсүрэнг томилжээ.



Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгч Л.Атарцэцэг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 196 дугаар зарлигаар Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилогдлоо.



Тайлангийн хугацаанд О.Зандрааг Ерөнхий шүүгчийн ажлын албаны Захиргааны хэргийн шүүн таслах ажиллагаа хариуцсан зөвлөхөөр, Г.Баттуяаг Шүүгчийн туслах-шинжээчийн, Б.Тунамалыг Захиргааны хэргийн хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээчийн, Н.Нямдаваа нарыг Гэмт хэргийн тухай хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээчийн, Э.Бадамдорж, Т.Даваажаргал, Д.Долгордорж, Э.Номин-Эрдэнэ, Б.Уранзаяа, Ч.Уранбилэг нарыг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтний албан тушаалд, Б.Мөнхтунгалагийг няравын, Ц.Билгүүнийг бичиг хүргэгчийн, Ч.Баатарчулууныг жолоочийн, Ц.Сайханааг үйлчлэгчийн ажилд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн тус тус томилж, өөрийн хүсэлтээр төрийн албанаас 5 ажилтан чөлөөлөгдсөн байна.

Тамгын газрын даргын тушаалаар Эрх зүйн онол, арга зүйн асуудал хариуцсан референт Н.Мөнгөнцэцэгийг Практик судлалын хэлтсийн даргын, Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч А.Батдэлгэрийг Мэдээлэл лавлагааны ажил хариуцсан Ахлах шинжээчийн, Гэмт хэргийн тухай хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээч А.Баярцэцэгийг Эрх зүйн онол, арга зүйн асуудал хариуцсан референтийн, Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтэн Д.Мөнхцэцэгийг Архивын ажил хариуцсан ахлах мэргэжилтний, Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтэн Н.Энхжилийг Шүүгчийн туслах-шинжээчийн албан тушаалд томилон дэвшүүлэн ажиллуулжээ.

Хэлтсийн дарга Н.Мөнгөнцэцэг, Шүүгчийн туслах-шинжээч Б.Володя, С.Золбоо, Н.Нямдаваа, З.Оюунгэрэл нарын төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг шинээр буюу нэмэгдүүлэн, Төсвийн асуудал хариуцсан референт-нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг, Дотоод аудит хариуцсан ахлах шинжээч Х.Бадамжаргал, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний туслах-Ахлах шинжээч Э.Энхжаргал, Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан шинжээч-нягтлан бодогч Б.Хишигсүрэн, Цахим засаглал, хэвлэл мэдээлэл хариуцсан шинжээч Д.Оюунчимэг, Тамгын газрын туслах-шинжээч А.Эрдэнэт Шүүгчийн туслах-шинжээч Б.Володя, А.Энхжаргал, Архивын ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Тэгшдэлгэр, нарын зэрэг дэвийн нэмэгдлийг шинээр болон нэмэгдүүлэн, жолооч Г.Баянмөнх, Э.Бишрэл нарын ур чадварын нэмэгдлийг олгосон байна.

Тайлангийн хугацаанд төрийн захиргааны албан тушаалд **10** албан хаагч, үйлчилгээний ажилд **4** ажилтан томилогдож, **5** ажилтан ажлаас чөлөөлөгдсөн байна.

Үүнээс гадна **5** хүнийг албан тушаал дэвшүүлэн томилж, **5** хүнд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг, **9** хүнд зэрэг дэвийн нэмэгдлийг шинээр болон нэмэгдүүлэн, үйлчилгээний **2** ажилтанд ур чадварын нэмэгдлийг тус тус олгожээ.

2019 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтэн Д.Долгордорж Шүүхийн Ерөнхий зөвлөлийн “Хүндэт” тэмдгээр шагнагдлаа. Тэрээр 2003 оноос хойш өнөөдрийг хүртэл тасралтгүй 16 жил шүүхийн захиргааны байгуулагад ажиллахдаа шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүгчийн туслах болон захиргааны ажлыг үр бүтээлтэй эрхэлж ирсэн юм.



### **4.2.3 Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах талаар:**


Тамгын газрын дарга 2019 онд хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **194** тушаал, үүнээс үндсэн үйл ажиллагааны чиглэлээр **88**, хүний нөөцийн удирдлагын чиглэлээр **106** тушаал тус тус гаргажээ.

Тайлангийн хугацаанд дараах журам, дүрэм, хөтөлбөр, төлөвлөгөөг судлаж, боловсруулж, батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Үүнд:

- “Монгол Улсын Дээд шүүхийн 2019-2023 оны стратеги төлөвлөгөө”,
- “Орон сууцны дэмжлэг олгох” журам;
- “Монгол Улсын Дээд шүүх”, “Дээд шүүхийн мэдээлэл”, “Монголын төр эрх зүй” сэтгүүлүүдийг эрхлэн гаргах, түүнийг түгээх журам;
- “Улсын Дээд шүүхийн төрийн захиргааны ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, түүний үр дүн, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг тооцож, мөнгөн урамшуулал олгох” журам;
- Шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах зорилгоор аюулгүйн үзлэг шалгалтад ашиглаж буй рентген төхөөрөмжийн “Цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм”, “Цацрагийн хамгаалалтын хөтөлбөр”, “Цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө”;
- “Шүүгчдийн зөвлөгөөний дэг” зэрэг болно.

Тайлангийн хугацаанд **448** өргөдөл гомдол, **1121** албан бичиг, **3664** хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, уг албан бичгүүдийг Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүн, шүүгч, Тамгын газрын даргад танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хуваарилан өгч шийдвэрлүүлснээс гадна **4656** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлжээ.

Бичиг хэргийн эргэлтийг өмнөх онтой харьцуулбал:



Авлигын эсрэг хууль, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг **2018** оны байдлаар шинэчлэгдсэн маягтыг дахин гаргуулан авч, **23** шүүгчийн материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлд, захиргааны албан хаагч **54** хүний материалыг Тамгын газарт зохих журмын дагуу хадгалж, цахим хэлбэрээр шинэчлэн гаргажээ.

Захиргааны албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн **7** хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг “Авлигатай тэмцэх газар”-т хянуулахаар хүргүүлэн холбогдох зөвшөөрлийг авч, томилон ажиллуулжээ.

Түүнчлэн “Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан”-г шинэчилсэн програмын дагуу гаргаж, Төрийн албаны зөвлөлд тогтсон хугацаанд нь хүргүүлсэн байна.

“Билгийн тооллын хаврын тэргүүн сар-Цагаан сарын баяр”, “Хүүхдийн баяр” бусад тэмдэглэлт баяр, бүх нийтийн амралтын өдрүүдэд тухай бүр арга хэмжээг зохион байгуулж, Улсын Дээд шүүх дээр сахилга, хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг өндөржүүлэх зорилгоор Тамгын газрын даргын **6** удаагийн тушаалаар **13** ажилтныг хариуцлагатай эргүүлээр томилон ажиллуулсан байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д “Хуульч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсны дараа шүүхэд төлөөлөх эрх нээлгэхээр Улсын Дээд шүүхэд бүртгүүлж ... өмгөөлөгчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдэнэ.” гэж заасны дагуу Тамгын газрын даргын тушаалаар энэ онд **289**, нийт **3142** хуульчдад өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийг тус тус нээж, гэрчилгээ, үнэмлэх олголоо. Өмгөөллийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулинд заасны дагуу шүүхэд төлөөлөх эрх нээлгэсэн хуульчдын бүртгэлийг Улсын Дээд шүүх Өмгөөлөгчдийн холбоонд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна.

Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүн, шүүгчид, Тамгын газрын дарга нар тус шүүхэд ажиллаж байгаад гавъяаныхаа амралтад гарсан ахмадуудаа 2019 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр, 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрүүдэд тус тус хүлээн авч уулзан хүндэтгэл үзүүллээ.





Түүнчлэн 2019 оны 07 дугаар сарын 02-09-ний өдрүүдэд Оросын Холбооны Улсын Улан-Үдэ хотоор аялуулан, тэднийг нийгмийн амьдралд идэвхитэй оролцуулах, залуу үеийнхэнд арвин туршлагаасаа хуваалцах зэрэг олон талт ажилд тэдний оролцоог дэмжих ажлыг зохион байгууллаа.



#### **4.2.4 Архивын ажлын талаар**

Улсын Дээд шүүхийн архивын баримтын хадгалалт, хамгаалалтын стандартыг хангасан техник, тоног төхөөрөмжөөр хангах зорилтыг дэвшүүлэн ажиллалаа.

Тус шүүхийн архив нь 1998 онд батлагдсан Архивын тухай хууль, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан "Байгууллагын архивын ажлын үндсэн заавар", Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2019 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Иргэн, захиргааны хэргийн баримтын төрөлжсөн архивын ажлын заавар, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2019 оны А/18, 34, А/31 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох баримтыг архивт хадгалах заавар", "Эрүүгийн хэргийн төв болон салбар

архивт хадгалагдаж байгаа баримтыг хадгалах хугацааны заавар"-ыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Улсын Дээд шүүхийн Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлд **204** баримт, Түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлд **142** баримт, 70 жил хадгалах хадгаламжийн бүртгэлд **6** баримт, нийт **352** баримтыг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан хүлээн авч, архивын нэгж үүсгэн хадгалж байна.

Архивын 2019 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр хадгаламжийн нэгж нь дараах төрөлд ангилагдаж байна. /хүснэгтээр харуулав/

д/д	Хадгаламжийн нэгж	Он	Хадгаламжийн нэгж
1.	Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн баримт	1996-2018	1902
2.	Түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл	1994-2018	1548
3.	70 жил хадгалах баримтын бүртгэл	1987-2018	52
4.	Дээд шүүх өөрийн эрхээр таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг	1974-2001	305
5.	Иргэний хэрэг	1974-2005	46
6.	Захиргааны хэрэг	2017	3
7.	Кино, гэрэл зураг, дуу, дүрсний баримт		4797
8.	<b>БҮГД</b>	<b>1996-2018</b>	<b>8653</b>

Байгууллагын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хуралдаанаар байнга, түр болон 70 жил хадгалах 2013-2018 оны баримт бичгийн бүртгэлийг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

#### **4.2.5 Номын сангийн ажлын талаар**


Тус шүүхийн номын сан нь Монгол, Англи, Герман хэл дээр улс төр, эрх зүйн онол, шүүх судлал, үндсэн хуулийн эрх зүй, эрүү, иргэн, захиргааны эрх зүй, хууль зүйн мэргэжлийн толь бичиг зэрэг **5841** ном, сэтгүүлийн фондтой болжээ.

“Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, “Үндэсний шуудан”, “Монголын үнэн” “Засгийн газрын мэдээ” “Өглөөний сонин” “Ардчилал таймс”, “Монголын мэдээ” зэрэг 9 төрлийн сонин, “Төрийн мэдээлэл”, Дээд шүүхийн “Мэдээлэл”, “Монголын төр эрх зүй”, “Хууль дээдлэх ёс”, “Төрийн захиргаа” зэрэг 5 төрлийн сэтгүүлийг ангилан байрлуулж, уншигчдад үйлчилж байна.

#### **4.2.6 Цагаатгалын бүртгэлийн талаар:**

Цагаатгалын ажил хариуцсан шинжээч нь **395** иргэнд “Цагаатгалын бүртгэл” болон “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгасан тухай үнэмлэхийг олгосон тухай бүртгэл”-д байгаа мэдээллийг шүүж өгч, зөвлөгөө өгсөн байна.


Иргэдтэй уулзаж зөвлөгөө мэдээлэл өгсөн байдлыг өмнөх онтой харьцуулбал:



Улсын Ерөнхий прокурор,


Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, Тагнуулын Ерөнхий газрын Тусгай архив, Иргэний хэргийн анхан шатны шүүхүүд зэрэг байгууллагуудаар дамжуулан **162** өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, хуулийн хугацаанд хариуг өгчээ.

Хүлээн авсан өргөдлийг өмнөх онтой харьцуулбал:




Тайлангийн хугацаанд Улсын Ерөнхий прокурорын газраас Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгуулахаар ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн Улсын Дээд шүүхээс **9** хэлмэгдэгчдийг цагаатгаж, “Цагаатгалын бүртгэл”-ийн системд нэмж орууллаа.

Хэлмэгдэгчдийн цагаатгасан байдлыг өмнөх онтой харьцуулбал:



Хэлмэгдэгчийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан **124** өргөдөл, хүсэлт хүлээн авч, шинээр **21**, нөхөж **67**, нийт **88** цагаатгалын үнэмлэхийг олгожээ.

### Цагаатгалын үнэмлэх олгосон байдал:



Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор нөхөх олговор нэхэмжлэх хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгаж, улс төрийн хилс хэрэгт холбогдуулан цаазаар авах ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчийн эхнэр, /нөхөр/ эсхүл хэлмэгдэгчийн төрсөн болон үрчилж авсан хүүхдэд **80.0** сая төгрөг, хорих ялаар шийтгүүлсэн бол **40.0** сая төгрөгийн нэг удаагийн нөхөн олговор олгох эрх зүйн орчин бүрдсэнээр Улсын Дээд шүүхэд хандах иргэдийн тоо өссөн үзүүлэлттэй байна.

#### **4.2.7 Тэмцээн уралдаан:**

Дорноговь аймгийн Сайншанд суманд зохион байгуулагдсан “Монголын шүүхийн шилжин явах цомын төлөөх хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн-2019”-т тэмцээнд А.Эрдэнэт ахлагчтай Улсын Дээд шүүхийн баг тамирчид тэргүүн байр эзэлж, алтан медаль хүртлээ.



### **4.3 ШҮҮХИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Улсын Дээд шүүхийн вэб сайтад хяналтын шатны шүүх хуралдааны эрүүгийн 727, иргэний 1174, захиргааны 638 зар, тоймыг тус тус байршууллаа. Хяналтын шатны шүүх хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангаж эрүүгийн 685, иргэний 1032, захиргааны 564 хэргийн шүүх хуралдааны тэмдэглэл хөтөлж, шүүх хуралдааны явцыг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулан, шүүх хуралдааны тэмдэглэлийг ёсчлуулан хэргийн оролцогчдод хуульд заасан хугацаанд танилцуулж, бүртгэл хяналтын системд байршуулан, хэргийн материалд хавсаргажээ.

Мөн хяналтын шатны шүүхээр 2019 онд хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн тогтоолуудыг [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) сайтад зохих журмын дагуу байршуулан ажиллаж байгаагаас эрүүгийн 530, иргэний 931, захиргааны 342 тогтоолыг цахим санд байршуулаад байна.

Тайлангийн хугацаанд хяналтын шатны шүүхийн “Шүүхийн захиргааны хяналт-шинжилгээний сар тутмын мэдээ”-г [administration@judcouncil.mn](mailto:administration@judcouncil.mn) цахим хаягаар, шүүн таслах ажиллагааны улирал, хагас, бүтэн жилийн тайланг “Шүүхийн статистикийн мэдээлэл, тайлан гаргах журам”-ын дагуу шинэчлэгдсэн хураангуй маягтаар гаргаж албан бичиг болон цахим хэлбэрээр Шүүхийн Ерөнхий зөвлөлийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнд [jud\\_research@judcouncil.mn](mailto:jud_research@judcouncil.mn) хаягаар тус тус хугацаанд нь хүргүүлэн ажиллажээ.

Мөн тайлангийн хугацаанд З.Пагмажав, Р.Эрдэнэбүрэн, Д.Жавхлан, М.Амарболд, Б.Тодзаяа нарт холбогдох эрүүгийн хэрэг, “Онч шийдэл” НҮТББ нэхэмжлэлтэй Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад холбогдох, “Алтайн гянт” ХХК-ний нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, “Ноён уулаа аврах хөдөлгөөн” НҮТББ-ын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, “Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам”-ыг улсын бүртгэлд бүртгүүлэх, “Ард түмний олонхийн засаглал нам”-ын даргын өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх зэрэг онцлох шүүх хуралдаанууд болж өнгөрлөө.



#### **4.4 ШҮҮХИЙН ПРАКТИКИЙГ СУДЛАХ ЧИГЛЭЛЭЭР:**

Шүүхийн практик судлалын хэлтэс нь 2019 онд шүүхийн практикийг судлах, хууль тогтоомжид санал өгөх, хууль тогтоомжийн системчлэлийн ажлыг хийж гүйцэтгэх, ном товхимол, сэтгүүл гаргах чиглэлээр ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1. Шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгарч буй бэрхшээлийг судлах, шийдвэрлэх арга замыг тодорхойлох хүрээнд эрүүгийн 4, иргэний 4, захиргааны 4, нийт 12 судалгааг хийж гүйцэтгэлээ.

Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар 2018 онд хянагдсан эрүү, иргэн, захиргааны хэргийн өөрчлөгдсөн, хүчингүй болгосон тогтоол, шийдвэр, магадлалын алдаа зөрчлийн тоймыг хийж гүйцэтгэжээ. Дээрх алдаа зөрчлийн тоймыг жил бүр тогтмол хийдэг бөгөөд анхан болон давж заалдах шатны шүүхүүдийн нийтлэг алдаа зөрчлийг тогтоох, цаашид анхаарах асуудлуудыг хэлэлцэх, түүнчлэн хуулийг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх явдлыг хангахад чиглэгдэж байна.

Мөн анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн нийт шүүгчдийн ажлын ачааллын судалгааг хийж гүйцэтгэлээ. Иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхэд ажлын ачаалал их байгаа нь шүүхийн шийдвэрийн чанарт сөргөөр нөлөөлөхүйц түвшинд хүрээд байгаа талаар шийдвэр гаргах түвшний субъектүүдэд судалгааны үр дүнг танилцуулсан байна.

2. Шүүхээс хууль хэрэглэж байгаа практикийг судлах, шүүгчдийг мэдээллээр хангах ажлын хүрээнд эрүүгийн 5, иргэний 6, захиргааны 6, нийт 17 судалгааг хийж гүйцэтгэжээ.

Тухайлбал: гадаад улс орнуудын Дээд шүүхийн шүүгчдийн ажиллах бүрэн эрхийн хэмжээ, хугацаа, сэлгэн ажиллуулах байдлын талаар харьцуулан судаллаа. Олон улсын хэмжээнд Дээд шүүхийн шүүгчид ямар хугацаагаар бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаагаас хамааран тухайн улс орны Шүүх эрх мэдлийн хараат бус байдал улмаар иргэдийн шүүхэд итгэх итгэлийн асуудал хэмжигддэг байна.

3. Шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай санал өгөх хүрээнд эрүүгийн 5, иргэний 3, захиргааны 3, нийт 11 судалгааг хийж гүйцэтгэв.

“Хөнгөн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон хэргийн судалгаа”-г гүйцэтгэн хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөж шийдвэрлэсэн хэргийн талаар олон нийтэд цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл өгч, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналаа хүргүүлсэн.

Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хэсэгт зориулан сүүлийн арван жилийн байдлаар Гэр бүлийн тухай хуулиар хянан шийдвэрлэсэн хэргийн өсөлт, бууралт, шийдвэрлэсэн байдлын талаарх нарийвчилсан судалгааг хийсэн байна.

#### **4.4.1 Хууль тогтоомжийн системчлэлийн ажлын чиглэлээр:**

Улсын Их хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндсэн хуулийн цэцээс манайд ирүүлж байгаа Монгол Улсын хууль, Улсын Их хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, тогтоол, “Төрийн мэдээлэл” сэтгүүлүүдийг дугаар бүрээр нь хүлээн авч шүүгч, ажилтнуудад эх хувиар болон дотоод сүлжээгээр дамжуулан ашиглуулж, лавлагаа өгч, Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхим болон Практик судлалын хэлтсээс гаргасан тойм, зөвлөмжүүдийг тухай бүрт нь цахим санд оруулан шүүхийн мэдээллийн санг баяжуулан ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын хууль **99**-г хүлээн авч, үүнээс шинээр баталсан болон шинэчлэн найруулсан **13** хуулийг нэгдсэн санд оруулж, **76** хуульд нэмэлт, өөрчлөлт орж, **10** хууль хүчингүй болсныг эх хуульд тухай бүрт нь хийхийн зэрэгцээ нэгдсэн сан дахь хуулиудад өөрчлөлтийг орууллаа.

Мөн Улсын Их хурлын **86** тогтоол, Ерөнхийлөгчийн **2** зарлиг, Үндсэн хуулийн цэцийн **4** дүгнэлт, **4** тогтоол, Төрийн мэдээлэл сэтгүүлийн **40** дугаарыг хүлээн авч эх хувь болон нэгдсэн санд оруулсан байна.

#### **4.4.2 Ном товхимол, сэтгүүл эрхлэн гаргах чиглэлээр:**

“Монголын төр эрх зүй” сэтгүүлийн 2018 оны 4 дүгээр улирлын дугаарыг эрхлэн гаргалаа. Монголын төр эрх зүй сэтгүүлийн зөвлөлийг шинэчлэн батлуулж, Монголын төр эрх зүй сэтгүүлийн дизайныг сайжруулж, 2019 оны 4 дүгээр улирлын дугаарыг шинэ өнгө төрхтэйгээр хэвлэн гаргав.



#### **4.5 ШҮҮХИЙН ТӨСӨВ, САНХҮҮ, ДЭД БҮТЦИЙГ УДИРДАХ:**

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2019 оны төсвийн багцыг **28.5** тэрбум төгрөгөөр төлөвлөн Сангийн яам, Шүүхийн Ерөнхий зөвлөлд хүргүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар Улсын Дээд шүүхийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц **9.9** тэрбум төгрөгөөр батлагдсанаас урсгал үйл ажиллагааны санхүүжилт **5.9** тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилт **4.0** тэрбум төгрөгөөр батлагдсан юм.

Дээрх батлагдсан төсвийн хүрээнд хяналтын шатны шүүхийн үйл ажиллагаа тасралтгүй явагдах нөхцлийг бүрдүүлэх, шүүхийн үйлчилгээг шуурхай хүргэх, ажиллах ая тухтай нөхцлийг бүрдүүлэх, шүүгч эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрах баталгааг хангах, шүүхийн багц хуулиудыг хэрэгжүүлэхэд анхаарч, төсвийн хуваарилалтыг хийж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

2019 онд төсвийг үр ашигтай оновчтой хуваарилах зарчмыг баримталснаар улсын төвлөрсөн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр **5.9** тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилтээр **4.0** тэрбум төгрөгийн тус тус санхүүжилт авч урсгал төсвийн зардалд **5.0** тэрбум төгрөгийг зарлага гаргаж, **84.8** %-ийн төсвийн гүйцэтгэлтэй, хөрөнгө оруулалтын зардалд **3.9** тэрбум төгрөгийн зарлага гаргаж, **97.5** %-ийн төсвийн гүйцэтгэлтэй, нийт багцдаа гүйцэтгэл нь **91.1** хувьтай гарч байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх хэсэгт заасны дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан Улсын Дээд шүүхийн 2020 оны урсгал төсвийг **7.3** тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын төсвийг **13.7** тэрбум төгрөг буюу нийт **21.1** тэрбум төгрөгөөр төлөвлөж, хязгаарын саналыг боловсруулан хүргүүлж, Улсын Дээд шүүхийн 2020 оны төсвийг **9.2** тэрбум төгрөгөөр батлууллаа.

Улсын Дээд шүүхийн санхүүгийн анхан шатны баримт хөтлөлт, нягтлан бодох бүртгэлийг УСНББОУСтандартад нийцүүлэн 2018 оны жилийн эцсийн болон 2019 оны хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн зарлагын мэдээ, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, татварын тайлан мэдээг хуульд заасан цаг хугацаанд нь гаргаж, тооцоо нийлж ажиллалаа.

Шүүн таслах ажиллагааны аюулгүй байдлыг хангахад шаардагдах рентген, гар хайч, дагалдах тоног төхөөрөмж, шүүхийн тогтоол захирамж, бусад эрх зүйн акт хэвлэх, хувилах, сүлжээний төхөөрөмж, компьютер, принтер, өрөө тасалгааны хөшиг болон гал унтраах тоног төхөөрөмжийг суурилуулах, зарим өрөө тасалгааг



тавилгажуулах зэрэг худалдан авах ажлыг зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг хийж 6 байгууллагатай гэрээ байгуулан **778.1** сая төгрөгөөр санхүүжүүлээ.

Батлагдсан төсвийн зардлыг ангилалаар харуулвал:

- Хангамж, материалын зардалд **180,3** сая төгрөг буюу **3%**;
- Байр ашиглалтын зардалд **86,2** сая төгрөг буюу **1.4%**;
- Эд хогшил, урсгал засварын **206,6** сая төгрөг буюу **3.5%**;
- Цалин, хөлс нэмэгдэл **2,7** тэрбум буюу **45,7%**;
- Ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд **349,7** сая төгрөг буюу **5.9%**;
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд **238,0** сая төгрөг буюу **4%**;
- Бараа, үйлчилгээний бусад зардалд **146,3** сая төгрөг буюу **2.4%**;
- Бусад урсгал шилжүүлэг **1,7** сая төгрөг буюу **0,05%**;
- Норматив зардалд **4,6** сая төгрөг буюу **0.07%**;

- Томилолт, зочны зардалд **162,4** сая төгрөг буюу **2.7%** гүйцэтгэлтэй тус тус зарлага гаргаж, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг батлагдсан төсвийн дагуу сар бүр бүрэн санхүүжүүлж, дэмжин ажилласан байна.

Мөн эмчийн өрөө тасалгааг тохижуулах, ажиллагсадын нийгмийн асуудлыг дэмжихэд зориулж орон сууцны дэмжлэг болгож шүүгч, захиргаа болон үйлчилгээний ажилтан нийт 60 хүнд **890.0** сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон байна. Мөн шүүхийн ахмадуудыг сэтгэл санаа, эд материалаар дэмжих аяны хүрээнд **3.8** сая төгрөгийн дэмжлэг олгож, Байгаль нуурын амралтын газарт 20 ахмадыг амраах үйл ажиллагааг зохион байгуулж, санхүүжүүлж ажилласан болно. Шүүгч ажиллагсадыг тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 3 шүүгчийн **345.2** сая төгрөг, 2 захиргааны албан хаагчийн **38.3** сая төгрөг, нийт **383.5** сая төгрөгийн гүйцэтгэл гаргасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) болон Улсын Дээд шүүхийн сайт дахь Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, бүтэн жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш хэмжээтэй зардал зэрэг холбогдох шаардлагатай мэдээ, мэдээллүүдийг цаг тухай бүрт нь хуулийн хугацаанд оруулах, шүүхийн 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг [tender.gov.mn](http://tender.gov.mn) сайт дээр байршуулах

зэргээс гадна холбогдох тайлан, мэдээг гаргаж Сангийн яам болон бусад газруудад хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллалаа.

“Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем”-ийн програм хангамжинд Улсын Дээд шүүхийн 2018 оны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдэл, холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь багтаан оруулж, биелэлтийг хангаж, гүйцэтгэлээ. Мөн Засгийн газрын 2016 оны 193, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэл дахин үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу ТГД-ын 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Улсын Дээд шүүхийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд дахин үнэлгээ хийснийг холбогдох газруудад хүргүүлж, бүрэн тайлагнасан болно.

#### **Дүгнэвэл:**

Шүүхийн 2019 оны урсгал төсөв өмнөх оны урсгал төсвөөс 51.2 хувиар буюу **2.0** тэрбум төгрөгөөр нэмэгдэж, хөрөнгө оруулалтын төсөв 100 хувь буюу **4.0** тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналтын шатны шүүхийн хэвийн ажиллагааг хангахад зарцуулж, барилга байшинтай холбоотой их засвар, дэд бүтцийн шинэчлэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслээр хангах, дэмжлэг туслалцаа үзүүлэх зэрэг шүүхийн өмнө хүлээгдэж байсан ажиллах нөхцөл дээшлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлуудыг бүрэн гүйцэтгэж ажиллалаа.

2019 онд Үндэсний Аудитын газраас хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитад “Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж бидний ажлыг дүгнэсэн билээ.

Хяналтын шатны шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангахад эдийн засгийн баталгааг бэхжүүлэх, бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн шүүхийн зориулалтын барилга бусад шаардлагатай тоног төхөөрөмж, програм хангамжийн хэрэгцээ байгааг судалж, 2020-2021 оны төсвийн жилүүдэд батлагдсан төсвийн хүрээнд эрэмбэлэн хэрэгжүүлэх шаардлага мөн үүсч байна.

#### **4.6 ШҮҮХИЙН ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛТЭЙ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЛЭЭР:**

Улсын Дээд шүүхийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс үйл ажиллагаандаа шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах чиглэлээр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 14-ний “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг мэдээлэх” 77 дугаар тогтоол, холбогдох бусад хууль дүрэм журмуудыг мөрдлөг болгон ажиллалаа.

Тус хэлтэс тайлангийн хугацаанд Улсын Дээд шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагааны талаар давхардсан тоогоор:



✓ өдөр тутмын сонинд **73**,



✓ телевизэд **165**,



✓ радиод **59**,



✓ вэб сайтуудад **514** мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтлүүлж нэвтрүүлжээ.

Мөн телевизүүдийн урсдаг мэдээгээр давхардсан тоогоор **125** мэдээг олон нийтэд хүргэсэн байна.

Түүнчлэн Улсын Дээд шүүхийн **supremecourt.mn** сайтад **53** мэдээ мэдээллийг оруулж, Дээд шүүхийн facebook хаягт тухай бүр байрлуулж, мэдээллийн ил тод, нээлттэй шуурхай байдлыг ханган ажиллажээ.

Мөн хугацаанд “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг мэдээлэх журам”-д заасны дагуу шүүх хуралдаанд оролцох хүсэлтийг бүртгэн шүүх бүрэлдэхүүнд танилцуулж, сурвалжлах нөхцөлөөр хангасан байна. Түүнчлэн Улсын Дээд шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг сэтгүүлчид тодруулсан тохиолдолд холбогдох албан тушаалтанд танилцуулж, мэдээллээр хангаж ажиллалаа.

Мөн хугацаанд нийт **220** өдөр шүүх, шүүгчтэй холбоотой болон бусад асуудлар хэвлэлийн тойм бэлтгэн Ерөнхий шүүгч, шүүгчид, холбогдох бусад албан тушаалтнуудад тараан мэдээллээр хангасан байна.

#### **4.6.1 Телевизийн нэвтрүүлгийн чиглэлээр:**

Улсын Дээд шүүхийн ХМОНХХ-ээс МҮОНТ-д хүсэлт тавьсны үндсэн дээр “Монгол Улсын нэрийн өмнөөс” хэмээх шүүхийн дагнасан нэвтрүүлэгтэй болж, тус телевизийн програмын хөтөлбөрт оруулсан. “Монгол Улсын нэрийн өмнөөс” нэвтрүүлэг 2019 оны **2 дугаар сараас** эфирээр цацагдаж, тайлант хугацаанд нийт **14** нэвтрүүлгийг олон нийтэд хүргэжээ. Үүнд:

- Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс бэлтгэсэн сурвалжлага, тус шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Оюунчимэг, шүүгч Г.Ганбаатар нарын ярилцлага /2019.02.18/;

- Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс хийсэн сурвалжлага, тус шүүхийн Ерөнхий шүүгч Ж.Оюунтунгалагийн өгсөн ярилцлага /2019.03.04/;

- Үл хөдлөх хөрөнгийн барьцаа, үүнээс үүдэх үр дагаврын асуудлаарх зохиомжит нэвтрүүлэг /2019.03.19/;

- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох, хүүхэд үрчлэлтийн асуудлаарх зохиомжит нэвтрүүлэг /2019.04.01/;

- Цахим хэрэгсэл буюу facebook ашиглан залилан мэхэлсэн гэмт хэргийн талаарх зохиомжит нэвтрүүлэг /2019.04.29/;

- Улсын Дээд шүүхийн шүүгч Г.Банзрагчийн Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаа, үр нөлөө, тус шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэргийн талаар өгсөн ярилцлага /2019.05.13/;

- Улсын Дээд шүүхийн шүүгч асан, Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн дарга Д.Тунгалаг эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа болон гэр бүлийн маргааны талаар ярилцлага /2019.05.28/;

- Өмнөговь аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хийсэн сурвалжлага, тус шүүхийн Ерөнхий шүүгч Т.Дэлгэрмаагийн ярилцлага /2019.06.25/;

- Өмнөговь аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх, Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс хийсэн сурвалжлага /2019.07.02/;

- Газар эзэмших эрхтэй холбоотой асуудлаар хийсэн зохиомжит нэвтрүүлэг /2019.10.08/;

- Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хийсэн сурвалжлага, шүүх хуралдаан хойшлох шалтгаан нөхцөлийн талаарх ярилцлага /2019.11.05/;

- Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хийсэн сурвалжлага, залилангийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, уг гэмт хэргийн хохирогч болохоос сэрэмжлэх тухай ярилцлага /2019.11.19/;

- Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хийсэн сурвалжлага, хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, ялын бодлогын талаар ярилцлага /2019.12.10/;

- Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хийсэн сурвалжлага, авилга, албан тушаалын гэмт хэрэг, хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт, учирч буй бэрхшээлийн талаар ярилцлага /2019.12.24/ зэрэг болно.

Түүнчлэн Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимтай хамтарсан төлөвлөгөө боловсруулж, нийслэлийн дүүргүүдийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд нэвтрүүлэгт оролцож, өөрийн үйл ажиллагаа, шүүхээр шийдвэрлэгдэж буй зарим төрлийн гэмт хэргийн талаар бодит мэдээллийг олон нийтэд хүргэж байна.

#### **4.6.2 Сонин, сайтын нийтлэл, ярилцлагын чиглэлээр:**

Шүүхийн талаар бодит ойлголт олон нийтэд хүргэх үүднээс шүүх, шүүгчийн үйл ажиллагаа, шүүхийн шийдвэртэй холбоотой давхардсан тоогоор ярилцлага, нийтлэл, сурвалжлага, бүтэн жил, улирлын шүүн таслах ажлын дэлгэрэнгүй мэдээлэл, эмгэнэл нийт **53**-ыг сонин сайтад нийтлүүлжээ.

#### **4.6.3 Шүүх, шүүгчийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэлд хийсэн судалгааны чиглэлээр:**

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн даалгасны дагуу ХМОНХХ **2018 оны 1 дүгээр сараас 2019 оны 10 дугаар сарыг дуусталх 22 сарын хугацаанд** Шүүх, шүүгчийн үйл ажиллагаатай холбоотой сонин, сайтын мэдээлэлд судалгаа хийлээ. Дээрх судалгааг ХМОНХХ-ээс бэлтгэдэг сонин, сайтын тоймд үндэслэн хийсэн бөгөөд нийт **3259** мэдээлээс шүүмжлэлт бус мэдээллийг 5, шүүмжлэлт мэдээллийг 7 ангилалд хуваан нэгбүрчлэн судалгаа хийсэн болно. Түүнчлэн энэ судалгааны хүрээнд сар сараар мэдээллийн бааз бүрдүүлсэн. Судалгааны хүрээнд хэргийн талаар мэдээлэл өгч байгаа эх сурвалж, аль шатны шүүхийн мэдээллийг олон нийт илүү сонирхож байгаа, хэвлэлийнхэн болон олон нийтийн анхаарлыг хамгийн их татаж буй хэргийн талаар нарийвчлан судалж дүгнэлтдээ тусгаж, Ерөнхий шүүгчид танилцуулсан болно.

#### **4.6.4 Шүүхийн мэдээллийг нэг “суваг”-тай болгох чиглэлээр:**

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс өгсөн чиглэлийн дагуу Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Шүүхийн хэвлэл мэдээллийн хэлтэс, шүүхүүдийн олон нийттэй харилцах мэргэжилтнүүдтэй ярилцсаны үндсэн дээр “Шүүхийн мэдээ” гэсэн facebook болон twitter хаягийг нээж, бүх шатны шүүхийн мэдээллийг нэг сувгаар түргэн шуурхай өгөх ажлыг эхлүүллээ.

#### **4.6.5 Хяналтын шатны шүүхэд гомдол гаргах асуудлаар гарын авлага бэлтгэх:**

Хяналтын шатны шүүхэд эрүүгийн болон захиргааны хэрэгт гомдол гаргах асуудлаар гарын авлага, тараах материалын төслийг бэлтгэж, Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, Захиргааны хэргийн танхимын тэргүүнүүдэд хянуулж, хэвлэлтэд шилжүүлээд байна.

#### **4.7 ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН АЖЛЫН АЛБА:**

2019 онд Ерөнхий шүүгчийн ажлын алба нь нийт **458** хэрэг хүлээн авч, **447** хэргийг Ерөнхий шүүгчид танилцуулж, хариу өгсөн ба одоо **11** хэргийн үлдэгдэлтэй байна. Нийт эрүүгийн **129**, иргэний **224**, захиргааны **105** хэрэг, **45** албан бичиг, **59** өргөдөл хүлээн авч, албан бичиг, өргөдлийн зохих хариуг өгчээ.

Ерөнхий шүүгчтэй уулзах хүсэлт гаргасан иргэдийг сар бүрийн 4 дүгээр долоо хоногийн Пүрэв гаригт хүлээн авах хуваарийн дагуу **95** иргэнийг хүлээн авч, тэдний гомдол, хүсэлтэд хариу өгөх, холбогдох албан тушаалтнуудад тэдний санал, хүсэлтийг уламжлан танилцуулж, зохих хариу өгч ажиллалаа.

Ерөнхий шүүгчид хандсан **12** хэргийн талаар хариу өгсөн бөгөөд энэ хэргийн талаар дахин гомдол гарсан тул “Хэрэг, өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх журам”-д зааснаар Тамгын газрын дарга, Ерөнхий шүүгчид танилцуулан өргөдөл, материалыг буцааж, **13** хэргийн хугацааг 15-30 хоногоор сунгаж, зохих хугацаанд нь хариу өгсөн байна.

Дотоод аудит хариуцсан ахлах шинжээч нь Монгол Улсын Төсвийн тухай хууль, Дотоод аудитын дүрэм болон Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын хүрээнд шүүхийн захиргааны байгууллагыг бэхжүүлэх, шүүхийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд удирдлагад дэмжлэг үзүүлэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх, дотоод хяналтын үр ашигтай байдлыг хангах зорилгоор Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамж, албаны даргаар жил, улирлын ажлын төлөвлөгөөг батлуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Төрийн захиргааны албан хаагчдын хувийн хэргийг бүрдүүлэх, хөтлөх, нэмэгдэл хуудас бичих, баяжуулах, хадгалах ажиллагааг холбогдох журмын дагуу хөтөлдөг эсэхэд нийцлийн аудит хийж тайлан бэлтгэн зөвлөмж өгч, тайланд дурдсан зөрчлийг арилгах хугацаатай үүрэг өглөө.

Түүнчлэн “Шүүхийн захиргааны хяналт-шинжилгээний сар тутмын мэдээ”-ний хэрэгжилтэд;

- Ерөнхий шүүгчийн захирамжийн биелэлт, хэрэгжилтийн байдалд гүйцэтгэлд;
- Тамгын газрын даргын 2019 онд гаргасан эрх зүйн актын биелэлтэд тус тус гүйцэтгэлд;
- Улсын Дээд шүүхийн 2018, 2019 оны худалдан авах ажиллагааны тайланд;
- Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын хэрэгжилтийг хангах, мэдээллийг системд оруулах үйл ажиллагаанд нийцлийн;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд улирал бүр тогтмол дотоод аудит хийж тус тус тайлан бэлтгэсэн байна.


#### **4.8 ШҮҮХИЙН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА ХҮРЭЭНД:**

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжин тэлж шүүгч, ажилтнууд тив дэлхийн болон олон улсын бүсийн чуулга уулзалт, эрдэм шинжилгээний бага хуралд оролцож шүүн таслах ажиллагааны талаарх туршлага судлах ажил өргөжсөөр байна.

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын урилгаар Испанийн Вант Улсын Дээд шүүх, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Гадаад харилцааны хэлтсийн дарга бөгөөд ахлах шүүгч ноён Педро Феликс Алвараз де Бенито, Барселоны давж заалдах шатны шүүхийн шүүгч хатагтай Мириам де Роса Палацио нар 2019 оны 01 дүгээр сарын 16-20-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ.



Мөн Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн М.Батсуурь 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Хүний эрхийг хамгаалагчийн асуудал хариуцсан НҮБ-ын тусгай илтгэгч М.Форст тэргүүтэй төлөөлөгч нарыг хүлээн авч уулзлаа. Тусгай илтгэгч М.Форст Монгол Улс нь хууль, эрх зүйн шинэтгэл хийхдээ хүний эрхийн хамгаалагчдын ажлыг хязгаарлах бус, дэмжих орчныг бүрдүүлэх хэрэгтэй гэв. Мишель Форст нь хүний эрхийг хамгаалагчдын эсрэг халдлага гарч, шахалт дарамт зарим тохиолдолд бүртгэгдсэн хэдий ч тэдний эсрэг зохион байгуулалттай халдлага үйлдэх үзэгдэл байхгүйг онцлон тэмдэглэв.



Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Х.Батсүрэн, Иргэний хэргийн танхимын тэргүүн Х.Сонинбаяр, Захиргааны хэргийн танхимын тэргүүн М.Батсуурь, Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв нар 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Ханнс-Зайделийн сангийн Төв болон зүүн хойд азийн газрын дарга В.Ланге, Монгол дахь Ханнс-Зайделийн сангийн төлөөлөгчийн газрын тэргүүн Проф.др. Ц.Сарантуяа нарын төлөөлөгч нарыг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр ХБНГУ-ын шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын сонгон шалгаруулалт, сургалт, үйл ажиллагааны процессын талаар сонирхож, шүүхийн захиргааны мэргэшсэн ажилтан бэлтгэх





чиглэлээр туршлага судлах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн ба шүүхийн захиргааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг Ханнс-Зайделийн сангаар болон ХБНГУ-д сургагч багш илгээн сайн туршлага судлах боломжтойг онцолсон юм.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн М.Батсуурь, Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв нар Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн урилгаар 2019 оны 06 дугаар сарын 22-27-ны өдрүүдэд албан айлчлал хийсэн ОХУ-ын Хуульчдын холбооны дарга В.В.Блажеев тэргүүтэй төлөөлөгч нартай уулзлаа. Айлчлалын хүрээнд хоёр орны хамтын ажиллагааны хүрээнд талууд харилцан мэдлэг, туршлага солилцохын зэрэгцээ хуульчдыг чадавхжуулах, давтан сургах болон бусад чиглэлээр хамтран ажиллахаар боллоо.



Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Х.Батсүрэн, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Б.Цогт, шүүгч Б.Батцэрэн, Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв нар 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Ерөнхий Прокурорын газар, АНУ-ын Баарын Холбооны “Эрх зүйт ёс санаачилга” байгууллагатай хамтран 2019 оны 9 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Ял тохиролцох онол, эрх зүйн зохицуулалт болон хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа" сэдэвт сургалтын сургагч багш нар болох АНУ-ын Баарын Холбооны зөвлөх, Олон улсын боловсролын хөтөлбөрийн удирдагч, хадагтай Жесси Танненбаум, АНУ-ын Нью Йорк хотын холбооны прокурор нарыг хүлээн авч уулзлаа.

Тус сургалт нь хоёр улсын хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэхээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үргэлжлэл болох дээрх сургалт нь дотоодын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сайн туршлагыг өөрийн онцлогт тохируулан хуульчлах боломжийг эрэлхийлэх, хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх

чиглэлийг дэлгэрүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой гэж зохион байгуулагч нар тодорхойлж байна.



Шүүгч Б.Ундрах Япон Улсын хууль зүйн яамны Сургалт, судалгааны хүрээлэнгээс 2019 оны 10 дугаар сарын 13-19-ны өдрүүдэд тус улсын Токио хотноо зохион байгуулагдсан “Арилжааны хуулийн талаарх 2 дугаар хамтарсан сургалт”, иргэний хэргийн шүүхийн үйл ажиллагаатай танилцаж, худалдах, худалдан авах болон бусад арилжааны гэрээ, арилжааны хэрэг маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх процесс, эвлэрүүлэн жуулчлах ажиллагааны талаар санал солилцож, оролцлоо.

Шүүгч Д.Ганзориг, Б.Мөнхтуяа, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга, Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч З.Оюунгэрэл нар БНЭУ-ын Лакноу хотноо 2019 оны 11 дүгээр сарын 5-11-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Дэлхийн Ерөнхий шүүгч нарын дээд хэмжээний уулзалт”-д тус тус оролцлоо.



Шүүхийн даалгавар буюу эрх зүйн туслалцааг хилийн чандад илгээх болон хилийн чанадаас ирсэн хүсэлтийг Иргэний хэргийн хувьд хариуцах Дээд шатны байгууллага нь Улсын Дээд шүүх бөгөөд гадаад улсад нийт 12 шүүхийн даалгавар илгээснээс БНСУ-д 6, БНХАУ-3, Болгар-2, АНУ, Япон, Эстони улсуудад тус тус 1 шүүхийн даалгавар илгээгээд байгаагаас БНСУ-д илгээсэн 2, Болгар улсад илгээсэн шүүхийг даалгаврын хариу ирсэн байна.

Харин БНСУ 10, Болгар 2, Швейцар 1, ОХУ-аас 1 шүүхийн даалгавар тус тус ирүүлснийг харьяалах шүүхэд хүргүүлэн, гүйцэтгүүлэх арга хэмжээг авч ажиллав.

#### **4.9 СУРГАЛТЫН ТАЛААР:**

Өнгөрсөн онд шүүхийн сургалтын хөтөлбөр боловсруулах, шүүхийн хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, шүүхийн захиргааны ажилтныг дэмжих ажлын хүрээнд сургалтын агуулгыг шинэчлэх, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, шинээр батлагдсан хууль тогтоомжийн агуулгыг таниулах, хууль хэрэглээний чадвар олгох зорилт тавьж, хэрэгжүүлж ажиллалаа.

Тухайлбал, 2019 оны 01 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд Бичиг хэргийн ажилтныг Тагнуулын Ерөнхий газраас зохион байгуулсан “Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтныг мэргэшүүлэх” 12 цагийн сургалтад;

2019 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Архив, бичиг хэргийн ажилтнуудыг Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан “Байгууллагын архивын улсын үзлэг” сэдэвт сургалтад;

2019 оны 6 дугаар сарын 04-ний өдөр Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах референт, Тамгын газрын туслах нарыг Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Улсын Их хурлын харьяа байгууллага, төрийн захиргааны төв байгууллага, засгийн газрын агентлагийн хуулийн хэлтсийн дарга, хүний нөөцийн ахлах мэргэжилтэн нарын арга зүйн сургалтад;

2019 оны 6 дугаар сарын 12-27-ны өдрүүдэд Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан хаагчдыг Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн “Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх” зорилтын хүрээнд “Авлигын эсрэг-1 өдрийн хөтөлбөрт сургалт” сэдэвт сургалтад;

2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсээс зохион байгуулсан “Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем, Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем, Иргэн-2014 иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн ситем”-ийн

талаарх хэлэлцүүлэг, сургалтад тус шүүхийн шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга, шүүхийн захиргааны ажилтнууд идэвхтэй оролцож, хэргийн хөдөлгөөний удирдлага, мэдээллийн төвийн үйл ажиллагаатай танилцлаа.



Мөн 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Дээд шүүхийн Тамгын газрын ажилтнуудад “Байгууллагын төлөвлөгөө, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй”, “Шүүхийн ажилтны ёс зүй”, “Баримт бичгийн стандарт, тушаал, захирамж, хурлын тэмдэглэл болон удирдлагын бусад нэг төрлийн баримт бичгийн зохион бүрдүүлэх арга зүй”, “Мэдээллийн аюулгүй байдал” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, хамруулав.



Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдаж, хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоох” зорилтын хүрээнд Тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан хаагчид Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи, Нэгдсэн

Үндэстний Байгууллагын хамтран зохион байгуулсан “Мэргэшүүлэх багц сургалт” сэдэвт сургалтад хамрагдаж дууслаа. Цаашид сургалтад тогтмол оролцуулах ажлыг зохион байгуулах, давтамжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой зорилт дэвшүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

#### **4.9.1 Эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг:**

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын ажилтнууд дараахь хэлэлцүүлгүүдэд оролцжээ.

1. Шүүхийн практик судлалын хэлтсийн дарга Н.Мөнгөнцэцэг:

- 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдөр УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос зохион байгуулсан Ерөнхий хяналтын хэлэлцүүлэгт “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэж байгаа байдал” сэдвээр,

- 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим Хансс-Зайделийн сантай хамтран зохион байгуулсан “Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэхэд тулгамдаж буй асуудлууд” сэдэвт хэлэлцүүлэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлд зааснаар хэргийг прокурорт буцаах хууль зүйн үндэслэл, анхаарах асуудал” сэдвээр;

2. Эрх зүйн онол, арга зүйн асуудал хариуцсан референт А.Баярцэцэг 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдөр УИХ-ын Хүний эрхийн дэд хорооноос НҮБ-ын Эрүүдэн шүүлтийн эсрэг өдрийг тохиолдуулан зохион байгуулагдсан “Эрүүдэн шүүлт ба хүний эрх” сэдэвт хэлэлцүүлэгт “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн байдал, цаашид анхаарах асуудлууд” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлэв.

Түүнчлэн 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Шүүхийн практик судлалын хэлтсийн дарга Н.Мөнгөнцэцэг, Эрх зүйн онол, арга зүйн асуудал хариуцсан референт А.Баярцэцэг, шинжээч Б.Алтансүвд, Н.Нямдаваа нар УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос зохион байгуулсан “Эрүүгийн хууль болон бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хэлэлцүүлэгт;

- 2019 оны 12 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах референт С.Бурмаа Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Хуулиа дээдэлсэн, иргэдээ эрхэмлэсэн төрийн албаны төлөө” хэлэлцүүлэгт;

- 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр “Төрийн албаны ёс зүйн сахилга, хариуцлага” хуулийн төслийн хэлэлцүүлэгт тус тус оролцжээ.